

ҮНДСЭН СИСТЕМИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААГ ЗОХИЦУУЛАХ,
СИСТЕМ АШИГЛАЖ ҮЙЛЧИЛГЭЭ ҮЗҮҮЛЭХ,
МЭДЭЭЛЭЛ СОЛИЛЦОХ ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Энэ журмын зорилго нь мэдээлэл хариуцагч байгууллагуудын суурь болон төрөлжсөн мэдээллийн сангаас үндсэн болон дэмжих системд мэдээлэл нийлүүлэх, үндсэн болон дэмжих системээр дамжуулан төрийн байгууллага, хуулийн этгээд үйлчилгээ авах, хүн, хуулийн этгээдэд үйлчилгээ үзүүлэх замаар мэдээлэл солилцох, системийн тасралтгүй, хэвийн үйл ажиллагааг хангахтай холбоотой харилцааг зохицуулахад оршино.

1.2. Үндсэн систем нь “Үндэсний дата төв” УТҮГ (цаашид “Дата төв” гэх)-д байрших тархмал бүтэц бүхий төрийн мэдээлэл солилцооны “ХУР” систем байна.

1.3. Энэ журамд заасан дэмжих систем нь Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 18.5.1-д заасан танилт, нэвтрэлтийн систем, 18.5.3-т заасан албан бичиг солилцооны дундын систем, 18.5.5-д заасан мэдэгдэл хүргэх систем, 18.5.6-д заасан төрийн үйлчилгээний нэгдсэн систем байна.

1.4. Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 18.5.4-т заасан мэдээлэл солилцооны бүртгэлийн систем нь үндсэн системээр илгээсэн, хүлээн авсан мэдээллийг илгээсэн, хүлээн авсан хугацаа, илгээгч, хүлээн авагч, мэдээллийн агуулгыг илэрхийлсэн дахин давтагдашгүй утга болон бусад мэдээллийг гэрээ байгуулахгүйгээр тухай бүр бүртгэнэ.

1.5. Энэ журмыг Цахим хөгжил, харилцаа холбооны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага (цаашид “яам” гэх) болон түүний харьяа Төрийн үйлчилгээний асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага (цаашид “Агентлаг” гэх), И-Монгол академи Улсын төсөвт үйлдвэрийн газар (цаашид “Академи” гэх), Үндэсний дата төв Улсын төсөвт үйлдвэрийн газар (цаашид “Дата төв” гэх) болон мэдээлэл хариуцагч байгууллага, хуулийн этгээд тус тус дагаж мөрдөнө.

1.6. Яам нь үндсэн болон дэмжих системээр дамжуулан үйлчилгээ үзүүлэх үйл ажиллагааг нэгдсэн зохион байгуулалтаар хангах, үйлчилгээний гэрээ байгуулах үйл ажиллагааг хариуцан хэрэгжүүлнэ.

1.7. Агентлаг нь үндсэн болон дэмжих системээр дамжуулан үйлчилгээ үзүүлэх үйл ажиллагааг нэгдсэн зохион байгуулалтаар хангах, үйлчилгээг олон нийтэд сурталчлах, сургалт зохион байгуулах, Төрийн мэдээлэл солилцооны системд холбогдсон байгууллагуудын мэдээллийн системийн бэлэн байдал, гэрээний хэрэгжилтийг хангуулах, тайлагнах үйл ажиллагааг хариуцна.

1.8. Дата төв нь үндсэн болон дэмжих системээр мэдээлэл солилцох холболт үүсгэх, техникийн нөхцөл, шаардлагыг хангуулах, системийн үйлдлийн бүртгэл хөтлөх, төлбөр тооцохтой холбоотой үйл ажиллагааг хариуцан хэрэгжүүлнэ.

1.9. Академи нь үндсэн болон дэмжих системийн хөгжүүлэлт, хэвийн үйл ажиллагааг хангаж ажиллана.

Хоёр. Үндсэн системд мэдээлэл нийлүүлэх

2.1. Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 6.1-т заасан мэдээлэл хариуцагч нь Үндсэн системд мэдээлэл нийлүүлнэ.

2.2. Мэдээлэл хариуцагч нь үндсэн системд мэдээлэл нийлүүлэх хүсэлтийг Агентлагт гаргана.

2.3. Хүсэлтэд дараах мэдээллийг тусгана:

2.3.1. Нийлүүлэх мэдээллийн хэрэгцээ, шаардлага;

2.3.2. Нийлүүлэх мэдээлэл нь нээлттэй, хаалттай, хязгаарлалттай гэж үзсэн үндэслэл, тайлбар.

2.3.3. Мэдээлэл хариуцагч байгууллагын нэр, нийлүүлэх мэдээллийн агуулга, оролтын утга (нэр, төрөл, тайлбар), гаралтын утга (нэр, төрөл, тайлбар), алдааны тайлбар;

2.4. Мэдээлэл нийлүүлэх хүсэлтийг дараах дарааллын дагуу шийдвэрлэнэ:

2.4.1. Агентлаг нь энэ журмын 2.3-т заасан мэдээллийг ажлын 3 хоногийн хугацаанд хянан үзээд шаардлага хангасан тохиолдолд сүлжээний дүрэм тохируулах хүсэлтийг дата төвд хүргүүлнэ.

2.4.2. Дата төв нь сүлжээний дүрэм тохируулах хүсэлтийг ажлын 3 хоногийн хугацаанд шийдвэрлэж, хариуг агентлагт мэдэгдэнэ.

2.4.3. Агентлаг нь үйлчилгээг үндсэн системд байршуулах хөгжүүлэлт хийлгэх хүсэлтийг академид хүргүүлнэ.

2.4.4. Академи нь үйлчилгээг ажлын 15 хоногийн хугацаанд “ХУР” системд байршуулж, агентлагт мэдэгдэнэ.

2.4.5. Агентлаг нь энэ журмын 2.3-т заасан шаардлага хангаагүй хүсэлтийг үндэслэл, тайлбарын хамт мэдээлэл хариуцагчид буцаана.

2.5. Мэдээлэл хариуцагч “ХУР” системд байршуулсан мэдээлэлд өөрчлөлт оруулах:

2.5.1. Мэдээлэл хариуцагч нь Үндсэн системд нийлүүлсэн мэдээлэлд өөрчлөлт оруулах бол энэ журмын 2.3.2, 2.3.3-т заасан өөрчлөлтийн мэдээллийг тусгаж, хүсэлтийг агентлагт хүргүүлнэ.

2.5.2. Агентлаг нь хүсэлтийг ажлын 3 хоногийн хугацаанд хянан хөгжүүлэлт хийлгэх, үндсэн системд байршуулах хүсэлтийг академид хүргүүлнэ.

2.5.3. Академи нь хөгжүүлэлтийг ажлын 5 хоногийн хугацаанд хийж, өөрчлөлт оруулах хугацааг агентлагт мэдэгдэнэ.

2.6. Агентлаг нь үндсэн системд үйлчилгээг байршуулсан, өөрчлөлт оруулсан талаар дата төв, мэдээлэл нийлүүлэгчид нэгэн зэрэг мэдэгдэнэ.

2.7. Суурь болон төрөлжсөн мэдээллийн сангийн мэдээлэл хариуцагч нь үндсэн системээр дамжуулсан мэдээллийн түүхчилсэн бүртгэлд хандах боломжтой байна.

2.8. Агентлаг нь үндсэн системд мэдээлэл нийлүүлсэн мэдээллээр бүртгэл хөтөлж, тайланг улирал бүрийн сүүлийн сарын 20-ны өдөрт багтаан яаманд хүргүүлнэ.

Гурав. Үндсэн болон дэмжих системээр дамжуулан төрийн байгууллага, хуулийн этгээдэд үйлчилгээ үзүүлэх, мэдээлэл солилцох

3.1. Мэдээлэл хариуцагч болон хуульд заасны дагуу гэрээний үндсэн дээр төрийн тодорхой чиг үүргийг гүйцэтгэж байгаа этгээд үйлчилгээг үнэ төлбөргүй үзүүлнэ.

3.2. Хуулийн этгээдэд үзүүлэх үйлчилгээний төлбөрийг энэ журмын 2 дугаар хавсралтаар баталсан зардал тооцох аргачлалын дагуу тооцно.

3.4. Мэдэгдэл хүргэх системээр дамжуулан тусгай дугаарт мэдэгдэл хүргэх бол төлбөрийг мэдээлэл хариуцагч байгууллага хариуцна.

3.5. Үндсэн системд нийлүүлсэн Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 9.2-т заасан хязгаарлалттай мэдээллийг ашиглах бол мэдээлэл нийлүүлэгчийн зөвшөөрлийг авна.

3.6. Хүн, хуулийн этгээдэд хамаарах хязгаарлалттай мэдээллийг ашиглахдаа мэдээллийн эзний зөвшөөрлийг авна.

3.7. Хүнд хамаарах хаалттай мэдээллийг холбогдох журмын дагуу ашиглана¹.

Дөрөв. Үндсэн болон дэмжих системийн тасралтгүй, хэвийн үйл ажиллагааг хангах

4.1. Агентлаг, дата төв, академи, мэдээлэл хариуцагч байгууллага, хуулийн этгээд системд гэмтэл, саатал үүсэх, эсхүл төлөвлөгөөт зогсолтын улмаас үйлчилгээ үзүүлэх боломжгүй болсон тохиолдолд нөхцөл байдлын талаарх мэдээллийг энэ журмын 4.4-т заасан хугацаанд мэдэгдэх, 4.5-д заасан хэвийн үйл ажиллагааг хангах арга хэмжээг авч, системийн найдвартай ажиллагааг хангахад хамтран ажиллана.

4.2. Кибер халдлагын улмаас системийн хэвийн үйл ажиллагаа, мэдээллийн аюулгүй байдал алдагдахад Кибер аюулгүй байдлын тухай хуулийн 20 дугаар зүйлд заасан кибер халдлага зөрчилтэй тэмцэх төвүүдэд мэдэгдэнэ.

¹ 10.3. Хүнд хамаарах хаалттай мэдээллийг мэдээллийн эзний зөвшөөрлөөр хуульд заасан зорилго, нөхцөл, журмын дагуу ашиглана.

4.3. Дата төв системийн ачааллыг хянах, тасалдал, саатал, гэмтлийн үед мэдээлэл солилцох, бүртгэлжүүлэх, тайлагнах үйл ажиллагааг цахим системээр зохион байгуулна.

4.4. Системийн хөгжүүлэлт, төлөвлөгөөт ажил, гэмтэл, тасалдал, саатлын үед мэдээлэл солилох, мэдэгдэх хугацаа:

4.4.1. Дата төв, академи нь үндсэн болон дэмжих системд урьдчилан төлөвлөсөн хөгжүүлэлт хийх, сүлжээнд техникийн үзлэг, шалгалт хийх зорилгоор үйл ажиллагааг хэсэгчлэн болон бүрэн зогсоох бол ажлын 3 өдрийн өмнө агентлаг, мэдээлэл хариуцагч байгууллага, хуулийн этгээдэд мэдэгдэнэ;

4.4.2. Агентлаг энэ журмын 2.5.3-т заасан өөрчлөлт оруулах хугацааг дата төв, мэдээлэл хариуцагч байгууллага, хуулийн этгээдэд урьдчилан мэдэгдэнэ.

4.4.3. Агентлаг мэдээлэл хариуцагч, хуулийн этгээдээс хамааралтай тасалдал, саатал илэрсэн бол тухайн байгууллагад даруй мэдэгдэнэ.

4.4.4. Үндсэн болон дэмжих системд үйлчилгээний холболт, хөгжүүлэлт хийх явцад мэдээлэл хариуцагчийн холбогдох мэдээлэлд өөрчлөлт оруулсан бол дата төв, академи харилцан мэдэгдэнэ;

4.4.5. Дата төв, академи нь үндсэн болон дэмжих системд гэмтэл, саатал гарсан тохиолдолд агентлаг, мэдээлэл хариуцагч байгууллага, хуулийн этгээдэд даруй мэдэгдэнэ;

4.4.6. Агентлаг тасалдал, саатал, гэмтэл бүрэн шийдвэрлэгдэж, сервис, систем хэвийн үйл ажиллагаанд орсон талаарх мэдээллийг тухайн мэдээлэл нийлүүлэгчид хяналтын систем болон цахим шуудангаар мэдэгдэнэ;

4.4.7. Ноцтой гэмтлийг шууд удирдлагад мэдэгдэж, систем хэвийн болох хүртэл 2 цаг тутамд мэдээллээр хангана;

4.4.8. Дата төв, академи нь тасалдал, саатал, гэмтэлтэй холбоотой тайлан мэдээг 14 хоног тутам агентлагт хүргүүлнэ;

4.5. Системийн гэмтэл, саатлын үед дараах хугацаанд хариу арга хэмжээг авна.

4.5.1. Системийн тасалдал, саатлын үед 2 цагийн дотор, төрийн үйлчилгээний нэгдсэн систем (оператор)-ийн хувьд 15 минутын дотор;

4.5.2. Системийн гэмтлийн үед 4 цагийн дотор;

4.5.3. Системийн ноцтой гэмтлийн үед 24 цагийн дотор;

4.6. Агентлаг улирал тутамд төлөвлөгөөт ажил, тасалдал, саатал, гэмтлийн талаарх болон хэвийн үйл ажиллагааг хангаж ажилласан тайланг нэгтгэж яаманд хүргүүлнэ.

4.7. Үндсэн системийн хэвийн найдвартай ажиллагааг хангах талаар дата төв, академи дараах арга хэмжээг хэрэгжүүлнэ:

4.7.1. Сүлжээний холболтын найдвартай байдлыг хангах;

4.7.2. Системд холбогдох холболтыг үнэн зөв хийх;

- 4.7.3. Үндсэн болон дэмжих систем, мэдээлэл хариуцагч, хэрэглэгчийн системээс хамааран нийтлэг гардаг тасалдал, саатлын үед хариу арга хэмжээ авах заавар, зөвлөмжөөр хангах;
- 4.8. Мэдээлэл хариуцагч байгууллага өөрийн хариуцсан системийн хэвийн найдвартай ажиллагааг хариуцах ажлын хүрээнд дараах арга хэмжээг хэрэгжүүлнэ:
- 4.8.1. Хяналтын системд хэрэглэгчийн бүртгэл үүсгүүлэх, хэрэглэгч өөрчлөгдсөн тохиолдолд тухай бүр мэдэгдэж, шинэчлүүлэх;
- 4.8.2. Тасалдал, саатлыг бүртгэгдсэнээс хойш нэн даруй арга хэмжээ авах;
- 4.8.3. Үндсэн системд мэдээлэл нийлүүлж байгаа системийн нууц үгийг тогтмол шинэчлэх;
- 4.8.4. Өөрийн хариуцан ажиллаж байгаа сервер болон мэдээллийн сангийн тасалдалгүй найдвартай ажиллагааг ханган ажиллах;
- 4.8.5. Үндсэн болон дэмжих системд холбогдсон системд тасалдал, гэмтэл, саатал гарсан даруйд энэ журмын 4.3-т заасан цахим системд мэдэгдэл хүргэх нөхцөлийг бүрдүүлэх.
- 4.9. Үндсэн дэмжих системээс үйлчилгээ авч буй мэдээлэл хариуцагч, хуулийн этгээд нь дараах арга хэмжээг хэрэгжүүлнэ:
- 4.9.1. Хяналтын системд хэрэглэгчийн бүртгэл үүсгүүлэх, хэрэглэгч өөрчлөгдсөн тохиолдолд тухай бүр мэдэгдэж, шинэчлүүлэх;
- 4.9.2. Өөрийн хариуцан ажиллаж байгаа сервер болон мэдээллийн сангийн тасалдалгүй найдвартай ажиллагааг хангах;
- 4.9.3. Мэдээллийн аюулгүй байдлыг хангах дотоод журам баталж үйл ажиллагаандаа мөрдөх;
- 4.9.4. Мэдээлэл алдагдсан үед авах арга хэмжээ, мэдээллийн эзэн болон холбогдох төрийн байгууллагад мэдээлэл хүргэх төлөвлөгөөг баталсан байна;

Тайлбар: Систем, сервисийн үйл ажиллагааг 2 цагийн дотор шалгаж, хэвийн ажиллагаанд оруулж болохуйц гэмтлийг хэвийн тасалдал, саатал гэж үзнэ.

“Саатал” гэж үндсэн болон дэмжих систем, мэдээлэл хариуцагчийн системийн хэвийн үйл ажиллагаа 60 минут хүртэлх хугацаагаар доголдохыг;

“Гэмтэл” гэж үндсэн болон дэмжих систем, мэдээлэл хариуцагчийн системийн хэвийн үйл ажиллагаа 60 минутаас дээш хугацаанд тасалдах болон гэмтэл гарсан нь тогтоогдсоныг;

“Ноцтой гэмтэл” гэж үндсэн болон дэмжих систем, мэдээлэл хариуцагчийн системийн хэвийн үйл ажиллагаа 48 цагаас дээш алдагдах нь тодорхой болсныг;

ҮНДСЭН БОЛОН ДЭМЖИХ СИСТЕМ АШИГЛАН
ҮЙЛЧИЛГЭЭ ҮЗҮҮЛЭХ ГЭРЭЭНИЙ ЗАГВАР, ЗАРДАЛ ТООЦОХ АРГАЧЛАЛ,
ГЭРЭЭ БАЙГУУЛАХ ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Энэ журмын зорилго нь үндсэн болон дэмжих системээр дамжуулан төрийн байгууллага, хуулийн этгээд үйлчилгээ үзүүлэх, гэрээ байгуулах, үйлчилгээний зардал тооцохтой холбоотой харилцааг зохицуулахад оршино.

1.2. Хуулийн этгээдийн гэрээний төлбөрийг үйлдлийн бүртгэлээс амжилттай дуудсан сервисийн төлөвөөр тооцно.

Хоёр. Үндсэн болон дэмжих систем ашиглан үйлчилгээ үзүүлэх хүсэлтийг хүлээн авах, шийдвэрлэх, гэрээ байгуулах

2.1. Мэдээлэл хариуцагч, хуулийн этгээд нь үндсэн болон дэмжих системээр дамжуулан үйлчилгээ авах хүсэлтийг цахим гэрээний систем (geree.gov.mn)-ээр гаргана.

2.2. Мэдээлэл хариуцагч, хуулийн этгээд ХУР, ДАН системээс үйлчилгээ авах хүсэлтэд дараах мэдээллийг тусгана:

2.2.1. Мэдээлэл хариуцагч, хуулийн этгээдийн нэр, регистрийн дугаар, хаяг, холбоо барих мэдээлэл;

2.2.2. ХУР, ДАН системийг ашиглах зориулалт, холбогдож ажиллах системийн талаарх мэдээлэл бүхий албан бичиг;

2.2.3. Үндсэн систем, дэмжих системийн техникийн нөхцөл, шаардлагыг хангасан эсэх;

2.2.4. Ашиглах ХУР, ДАН систем, сервисийн сонголт;

2.2.5. ХУР, ДАН системд холбогдож ажиллах системд кибер аюулгүй байдлын эрсдэлийн үнэлгээ хийлгэсэн талаарх мэдээлэл;

2.2.6. Хязгаарлалттай мэдээллийг ашиглах бол мэдээлэл нийлүүлэгчийн зөвшөөрөл.

2.3. ХУР, ДАН системийн үйлчилгээний хүсэлтийг хүлээн авах, шийдвэрлэх:

2.3.1. Агентлаг хүсэлтийг хүлээн авч, дараах шаардлага хангаж байгаа эсэхийг шалгана:

2.3.1.1. Энэ журмын 2.2-т заасан мэдээлэл;

2.3.1.2. Сонгосон сервис нь үндсэн системийн үйлчилгээний жагсаалтад байгаа эсэх;

2.3.1.3. Хязгаарлалттай мэдээллийг хуульд заасан үндэслэл, журмын дагуу ашиглах эсэх;

2.3.1.4. Системд холболт хийхэд техникийн нөхцөл, шаардлага, аюулгүй байдлын шаардлагыг хангасан эсэх талаар дата төвөөс дүгнэлт гаргуулна;

2.3.2. Агентлаг нь энэ журмын 2.3.1-д заасан шаардлагыг хангасан тохиолдолд гэрээ байгуулах тухай мэдэгдлийг хүсэлт гаргасан мэдээлэл хариуцагч, хуулийн этгээдийн цахим шуудангаар хүргүүлж, цахим гэрээний системээр яаманд мэдэгдэнэ.

2.3.3. Хүсэлт гарагч нь энэ журмын 2.10.5-д заасан хугацаанд, яам нь 2.10.6-д заасан хугацаанд гэрээг тус тус батална.

2.3.4. Гэрээ батлагдсаны дараа агентлаг нь системд холбогдох тохиргооны файл, гарын авлагыг мэдээлэл хариуцагч, хуулийн этгээдийн цахим шуудангаар хүргүүлнэ.

2.3.5. Агентлаг нь энэ журмын 2.3.1-т заасан хүсэлтийг ажлын 3 хоногийн хугацаанд шийдвэрлэнэ.

2.3.6. Энэ журмын 2.3.1-д заасан шаардлага хангаагүй хүсэлтийг үндэслэл бүхий тайлбарын хамт буцаана.

2.4. Мэдээлэл хариуцагч байгууллага Төрийн үйлчилгээний нэгдсэн системээр дамжуулан үйлчилгээ үзүүлэх хүсэлтэд дараах мэдээллийг тусгана:

2.4.1. Мэдээлэл хариуцагч байгууллагын нэр, регистрийн дугаар, хаяг, холбоо барих мэдээлэл;

2.4.2. Үйлчилгээг нэвтрүүлэх зорилго, хэрэгцээ шаардлага, нийгэм, эдийн засгийн үр өгөөжийн тооцоо, лавлагаа, үйлчилгээний төлбөрийн талаарх мэдээлэл;

2.4.3. Холбогдож ажиллах системийн талаарх мэдээлэл;

2.4.4. Тухайн үйлчилгээг хүн, хуулийн этгээдэд хүргэх эрх олгосон хууль эрх зүйн зохицуулалт;

2.4.5. Холбогдож ажиллах системд кибер аюулгүй байдлын эрсдэлийн үнэлгээ хийлгэсэн талаарх мэдээлэл.

2.5. Төрийн үйлчилгээний нэгдсэн системээр дамжуулан үйлчилгээ үзүүлэх хүсэлтийг хүлээн авах, шийдвэрлэх:

2.5.1. Агентлаг хүсэлтийг хүлээн авч, дараах шаардлагыг хангаж байгаа эсэхийг шалгана:

2.5.1.1. Энэ журмын 2.4-т заасан мэдээлэл, бүрдэл;

2.5.1.2. Төрийн үйлчилгээний нэгдсэн системд байршсан үйлчилгээний давхардал байгаа эсэх;

2.5.1.3. Системд холболт хийхэд техникийн нөхцөл, шаардлага, аюулгүй байдлын шаардлагыг хангасан эсэх;

2.5.1.4. Кибер аюулгүй байдлын эрсдэлийн үнэлгээ хийлгэсэн дүгнэлт, зөвлөмж;

2.5.2. Агентлаг нь энэ журмын 2.5.1-д заасан шаардлагыг хангасан тохиолдолд гэрээ байгуулах тухай мэдэгдлийг хүсэлт гаргасан мэдээлэл хариуцагчийн цахим шуудангаар хүргүүлж, яаманд системээр мэдэгдэнэ.

2.5.3. Хүсэлт гаргагч нь энэ журмын 2.10.5-д заасан хугацаанд, яам нь 2.10.6-д заасан хугацаанд гэрээг тус тус батална.

2.3.4. Гэрээ батлагдсаны дараа агентлаг нь үйлчилгээ нэвтрүүлэх тухай мэдэгдлийг мэдээлэл хариуцагч, академийн цахим шуудангаар хүргүүлнэ.

2.3.5. Агентлаг нь энэ журмын 2.5.1-т заасан хүсэлтийг 5 хоногт, академи нь системд үйлчилгээ оруулах хөгжүүлэлтийг ажлын 15 хоногт гүйцэтгэж үр дүнг агентлагт мэдэгдэнэ.

2.3.6. Энэ журмын 2.5.1-д заасан шаардлага хангаагүй хүсэлтийг үндэслэл бүхий тайлбарын хамт буцаана.

2.6. Албан бичиг солилцооны дундын систем ашиглах хүсэлтэд дараах мэдээллийг тусгана:

2.6.1. Хүсэлт гаргагч хуулийн этгээдийн нэр, регистрийн дугаар, хаяг, холбоо барих мэдээлэл;

2.6.2. Албан бичиг солилцооны дундын системд холбогдох зорилго, хэрэгцээ шаардлага;

2.6.3. Холбогдож ажиллах системийн талаарх танилцуулга;

2.6.4. Албан бичиг солилцооны дундын системийн техникийн нөхцөл, шаардлагыг хангасан эсэх;

2.6.5. Холбогдож ажиллах системд кибер аюулгүй байдлын эрсдэлийн үнэлгээ хийлгэсэн талаарх мэдээлэл.

2.7. Албан бичиг солилцооны дундын системд холбогдох хүсэлтийг хүлээн авах, шийдвэрлэх, хариу өгөх

2.7.1. Агентлаг хүсэлтийг хүлээн авч, дараах дарааллын дагуу шийдвэрлэнэ:

2.7.1.1. Энэ журмын 2.6-д заасан бүрдлийг шалгаж, шаардлага хангасан бол гэрээний төслийг мэдээлэл хариуцагчийн цахим шуудангаар хүргүүлнэ.

2.7.1.2. Хүсэлт гаргагч нь энэ журмын 2.10.5-д заасан хугацаанд, яам нь 2.10.6-д заасан хугацаанд гэрээг тус тус батална.

2.7.1.3. Гэрээ батлагдсаны дараа агентлаг нь техникийн нөхцөл, шаардлагад нийцүүлэн системд холболт хийх хүсэлтийг академийн цахим шуудангаар хүргүүлнэ.

2.7.1.4. Академи нь Албан бичиг солилцооны дундын системд холбогдох туршилтын серверт хандах эрх олгох, холболт үүсгэх, туршилт хийх, системийн серверт холбох эрх олгох, холбогдох хөгжүүлэлтийг хийх ажлыг 14 хоногт гүйцэтгэж үр дүнг агентлагт мэдэгдэнэ.

2.8. Мэдэгдэл хүргэх систем ашиглах хүсэлтэд дараах мэдээллийг тусгана:

2.8.1. Хүсэлт гаргагч хуулийн этгээдийн нэр, регистрийн дугаар, хаяг, холбоо барих мэдээлэл;

2.8.2. Мэдэгдэл хүргэх зорилго, хэрэгцээ шаардлага, мэдэгдлийн агуулга, хугацаа, давтамжийн талаарх мэдээлэл;

2.9. Мэдэгдэл хүргэх систем ашиглах хүсэлтийг хүлээн авах, шийдвэрлэх, хариу өгөх

2.9.1. Агентлаг хүсэлтийг хүлээн авч, дараах дарааллын дагуу шийдвэрлэнэ:

2.9.1.1. Энэ журмын 2.8-т заасан бүрдлийг шалгаж, гэрээний төслийг мэдээлэл хариуцагчийн цахим шуудангаар хүргүүлнэ.

2.9.1.2. Хүсэлт гаргагч нь энэ журмын 2.10.5-д заасан хугацаанд, яам нь 2.10.6-д заасан хугацаанд гэрээг тус тус батална.

2.9.1.3. Гэрээ батлагдсаны дараа агентлаг нь мэдэгдэл хүргэх системийн эрх нээлгэх тухай хүсэлтийг академийн цахим шуудангаар хүргүүлнэ.

2.9.1.4. Академи нь мэдэгдэл хүргэх системийн эрх нээх, мэдээлэл хариуцагчид мэдэгдэх ажлыг 2 хоногт гүйцэтгэж үр дүнг агентлагт мэдэгдэнэ.

2.10. Гэрээ байгуулах

2.10.1. Үндсэн болон дэмжих систем ашиглан үйлчилгээ үзүүлэх гэрээг үндсэн, дэмжих систем тус бүрд нь байгуулна.

2.10.2. Гэрээ байгуулах тухай мэдэгдэл хүлээн авсан хүсэлт гаргагч нь энэ журмын хавсралтаар баталсан загвар гэрээг ажлын 2 хоногийн дотор тоон гарын үсгээр баталгаажуулж, цахим системээр хүргүүлнэ.

2.10.3. Яам цахим системээр ирүүлсэн гэрээний төслийг ажлын 3 хоногийн дотор хянан, тоон гарын үсгээр баталгаажуулж, хувийг цахим системээр хүсэлт гаргагчид, гэрээний хуулбарыг тагнуулын байгууллагад хүргүүлнэ.

2.10.4. Үндсэн систем болон дэмжих системээс үйлчилгээ үзүүлэх гэрээний хугацаа 3 жил байх бөгөөд гэрээг цуцлах талаар мэдээлэл хариуцагч, хуулийн этгээдээс хүсэлт ирүүлээгүй тохиолдолд гэрээг анх байгуулсан хугацаагаар нэг удаа сунгана.

2.10.3. Энэ журмын 2.10.4-т заасан хугацаанд үйлчилгээ нэмж авах тохиолдолд нэмэлт гэрээ байгуулна.

2.10.4. Яам нь энэ журмын 5.6-д заасан гэрээ цуцлах талаар дата төвөөс ирүүлсэн саналыг хүлээн авч ажлын 3 хоногт багтаан шийдвэрлэнэ.

Гурав. Гэрээний хэрэгжилтийг хангах талаар
яамны эрх, үүрэг

- 3.1. Үндсэн систем, дэмжих системийн үйл ажиллагааг боловсронгуй болгох арга хэмжээг авах;
- 3.2. Үндсэн систем, дэмжих системд холбогдох журам, заавар, аргачлалын хэрэгжилтийг зохион байгуулах;
- 3.3. Гэрээний бүртгэлийн санг хөтлөх;
- 3.4. Гэрээний хэрэгжилтийн тайланг улирал бүр хүлээн авч хэрэгжилтийг ажлын 10 хоногт багтаан дүгнэж, шаардлагатай тохиолдолд хэрэгжилтийг сайжруулах талаар зөвлөмж, чиглэл хүргүүлнэ.

Дөрөв. Гэрээний хэрэгжилтийг хангах талаар
агентлагийн эрх, үүрэг

- 4.1. Үндсэн болон дэмжих системээр дамжуулан үйлчилгээ үзүүлэх үйл ажиллагааг нэгдсэн зохион байгуулалтаар хангаж, хяналт тавина.
- 4.2. Үндсэн болон дэмжих системээс үйлчилгээ авах хүсэлтийг хүлээн авах, бүртгэх, шийдвэрлэх, эрх бүхий байгууллагад шилжүүлж шийдвэрлүүлэх, хариу мэдэгдэх;
- 4.3. Үндсэн болон дэмжих системд холболт хийлгэх хүсэлтийг дата төв, академид шилжүүлэх;
- 4.4. Үндсэн болон дэмжих системээр үзүүлж буй үйлчилгээтэй холбоотой асуудлаар зөвлөгөө, мэдээлэл өгөх;
- 4.5. Үндсэн болон дэмжих системд холбогдсон хэрэглэгчийн систем, сүлжээнд техникийн үзлэг, шалгалт хийх үйл ажиллагааг дата төв, академитай хамтран зохион байгуулах;
- 4.6. Хүн, хуулийн этгээдээс гаргасан үндсэн болон дэмжих системийн тасалдал, сааталтай холбоотой хүсэлтийг хүлээн авах, шийдвэрлэх;
- 4.7. Үндсэн болон дэмжих системийн үйлчилгээ, гэрээний хэрэгжилтийн тайланг улирал бүрийн сүүлийн сарын 20-ны өдөрт багтаан яаманд хүргүүлэх.

Тав. Гэрээний хэрэгжилтийг хангах талаар
дата төвийн эрх, үүрэг

- 5.1. Техникийн нөхцөл, шаардлагын дагуу үндсэн болон дэмжих системд үйлчилгээний холболт хийх;
- 5.2. Үйлчилгээний хандалт болон төлбөрийн мэдээлэл шалгах нөхцөлийг бүрдүүлэх;
- 5.3. Үндсэн болон дэмжих системийн түүхчилсэн бүртгэлийг хөтөлж, түүнд хяналт тавих;

5.4. Үндсэн болон дэмжих систем, сүлжээнд техникийн үзлэг, шалгалтын улмаас түр зогсолт хийх, гэмтэл, саатал гарсан тохиолдолд шаардлагатай арга хэмжээг авч хэрэгжүүлэх;

5.5. Гэрээ байгуулсан хуулийн этгээдэд гэрээнд заасан үүргээ биелүүлэх талаар шаардлага тавих, гарсан зөрчлийг арилгуулах;

5.6. Гэрээ байгуулсан хуулийн этгээд нь техникийн нөхцөл, шаардлагыг зөрчсөн, холбогдсон сүлжээгээр дамжуулан халдлагын шинжтэй үйлдэл хийсэн бол холболтыг зогсоож, гэрээг цуцлах саналыг яаманд хүргүүлэх;

5.7. Үндсэн болон дэмжих системтэй холбоотой гэрээний хэрэгжилтийн талаарх тайлан, мэдээг тогтоосон хугацаанд агентлагт хүргүүлэх;

5.8. Дата төвийн эрх, үүргийг хэрэгжүүлэхтэй холбоотой хуулийн этгээдийн гаргасан хүсэлтийг хүлээн авч шийдвэрлэх;

5.9. Үндсэн болон дэмжих системд холбогдох техникийн нөхцөл, шаардлагыг боловсронгуй болгох.

5.10. Хэрэглэгчийн систем, сүлжээнд техникийн үзлэг, шалгалт хийх, техникийн нөхцөл, шаардлагыг хангаж байгаа эсэхийг дүгнэх, зөвлөмж хүргүүлэх;

Зургаа. Гэрээний хэрэгжилтийг хангах талаар

академийн эрх, үүрэг

6.1. Техникийн нөхцөл, шаардлагын дагуу үндсэн болон дэмжих системийн хөгжүүлэлтийг хийх, үйлчилгээг байршуулах;

6.2. Мэдээлэл хариуцагчийн нийлүүлсэн мэдээлэлд өөрчлөлт орсон талаарх мэдэгдлийг хүлээн авч шийдвэрлэх;

6.3. Үндсэн болон дэмжих систем, сүлжээнд техникийн үзлэг, шалгалтын улмаас түр зогсолт хийх бол ажлын 3 өдрийн өмнө, системийн нэмэлт хөгжүүлэлтээс шалтгаалан сервист өөрчлөлт орсон тохиолдолд гэрээ байгуулсан хуулийн этгээдэд даруй мэдэгдэж, шаардлагатай арга хэмжээг авч хэрэгжүүлэх;

6.4. Академийн эрх, үүргийг хэрэгжүүлэхтэй холбоотой хуулийн этгээдийн гаргасан хүсэлтийг хүлээн авч шийдвэрлэх;

6.5. Үндсэн системд мэдээлэл нийлүүлэх, холболт хийх заавар, гарын авлагаар хангах;

6.6. Үндсэн болон дэмжих системийг боловсронгуй болгох;

6.7. Хэрэглэгчийн ашиглаж байгаа системд үзлэг, шалгалт хийх, техникийн нөхцөл, шаардлагыг хангаж байгаа эсэхийг дүгнэх, зөвлөмж хүргүүлэх;

Долоо. Гэрээний хэрэгжилтийг хангах талаар

хуулийн этгээдийн эрх, үүрэг

7.1. Үндсэн болон дэмжих систем ашиглахад тавигдах техникийн нөхцөл, шаардлагыг хангах;

- 7.2. Өөрийн хариуцсан мэдээллийн системийн хэвийн үйл ажиллагааг хангах, мэдээллийн аюулгүй байдлыг хангах талаарх дүрэм, журмыг дагаж мөрдөх;
- 7.3. Үндсэн болон дэмжих системээс авч байгаа мэдээллийг хуульд заасан үндэслэл, журмын дагуу ашиглах;
- 7.4. Мэдээллийн эзний зөвшөөрлийн үндсэн дээр хязгаарлалттай мэдээллийг ашиглах;
- 7.5. Хуульд заасны дагуу олж авсан хязгаарлалттай мэдээллийг мэдээллийн эзний зөвшөөрөлгүйгээр бусдад дамжуулахгүй, задруулахгүй байх;
- 7.6. Цахим хэлбэрээр үзүүлсэн үйлчилгээний түүхчилсэн бүртгэлийг хөтлөх;
- 7.7. Системийн хөгжүүлэлтийг гэрээний үндсэн дээр гүйцэтгүүлэх;
- 7.8. Үндсэн болон дэмжих системд холбогдсон системийг шинэчлэх, холбогдох туршилт хийх тухай бүр үйлчилгээ үзүүлэгч байгууллагад урьдчилан мэдэгдэх;
- 7.9. Энэ журмын 7.8-д заасан үүргийг биелүүлээгүйгээс үүдэн гарсан төлбөрийг хариуцах;
- 7.10. Системд холбогдон үйлчилгээ авахад ашиглаж буй токен, нэвтрэх эрхийг бусдад ашиглуулахгүй байх;
- 7.11. Гэрээ цуцлах, гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулах саналыг хүргүүлэх;
- 7.12. Үндсэн болон дэмжих системийг ашиглан цахим хэлбэрээр үйлчилгээ үзүүлэх ажилтан, албан тушаалтан цахим гарын үсэг хэрэглэх;
- 7.13. Гэрээ хэрэгжих хугацаанд хуулийн этгээдийг төлөөлөх эрх бүхий этгээдийн мэдээлэл өөрчлөгдсөн тохиолдолд энэ талаар даруй мэдэгдэх;
- 7.14. “ХУР” системээс мэдээллийг дуудах бүрд хуульд зааснаас бусад тохиолдолд мэдээллийг дуудаж байгаа тухайн хүн, хуулийн этгээдийн регистрийн дугаар, эсхүл иргэний бүртгэлийн дугаараар таньж тодорхойлох;

Тайлбар: “Амжилттай дуудсан сервис” гэж тухайн сервисийг дуудаж байгаа хэрэглэгчид ашиглаж болох хариуг буцаасан байхыг;

“Үндсэн болон дэмжих систем ашиглан
үйлчилгээ үзүүлэх гэрээний загвар,
зардал тооцох аргачлал, гэрээ
байгуулах журам”-ын 1 дүгээр
хавсралт

БАТЛАВ.

БАТЛАВ.

ҮНДСЭН СИСТЕМ (ХУР)-ИЙГ АШИГЛАН ҮЙЛЧИЛГЭЭ
ҮЗҮҮЛЭХ ГЭРЭЭНИЙ ЗАГВАР

№ ...

2025 оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар хот

Энэхүү гэрээг нэг талаас Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яам
(цаашид “яам” гэх), түүнийг төлөөлж

(албан тушаал, эцэг/эх/-ийн нэр, нэр),

Нөгөө талаас _____
(цаашид “Хэрэглэгч” гэх), түүнийг төлөөлж _____
(албан тушаал, эцэг/эх/-ийн нэр, нэр)

нар (хамтад нь “Талууд” гэх) дор дурдсан нөхцөлийг харилцан тохиролцож гэрээг
байгуулав.

Нэг.Нийтлэг үндэслэл

1.1.Талууд гэрээгээр хүлээсэн үүргээ хэрэгжүүлэхдээ Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хууль, Цахим гарын үсгийн тухай хууль, Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хууль, “И-Монгол академи” улсын төсөвт үйлдвэрийн газрын дүрэм, “Үндэсний дата төв” улсын төсөвт үйлдвэрийн газрын дүрэм, “Үндсэн системийн үйл ажиллагааг зохицуулах, систем ашиглаж үйлчилгээ үзүүлэх, мэдээлэл солилцох журам”, “Үндсэн болон дэмжих систем ашиглан үйлчилгээ үзүүлэх гэрээний загвар, зардал тооцох аргачлал, гэрээ байгуулах журам”, Үндсэн систем, дэмжих системийн техникийн нөхцөл, шаардлага, заавар, аргачлал болон бусад холбогдох хууль тогтоомж, эрх зүйн актыг дагаж мөрдөнө.

1.2.Энэ гэрээгээр хэрэглэгчийг үндсэн системд холбож, гэрээний хавсралтад заасан мэдээллийг дамжуулах үед үүсэх харилцааг зохицуулна.

1.3.Энэ гэрээнд хэрэглэсэн дараахь нэр томъёог дор дурдсан утгаар ойлгоно:

1.3.1.“Үндсэн систем” (цаашид “ХУР” гэх) гэж суурь болон төрөлжсөн мэдээллийн сангийн мэдээллийг хэрэглэгч ашиглах, мэдээлэл солилцох боломжийг бүрдүүлсэн “Үндэсний дата төв” УТҮГ-т байрших төрийн мэдээлэл солилцооны системийг;

- 1.3.2. “Хэрэглэгч” гэж гэрээ байгуулан үндсэн болон дэмжих систем ашиглаж байгаа төрийн байгууллага, хуулийн этгээдийг;
- 1.3.3. “Веб сервис” гэж цахим орчинд мэдээлэл солилцох боломжтой үйлчилгээг;
- 1.3.4. “Амжилттай дуудсан сервис” гэж тухайн сервисийг дуудаж байгаа хэрэглэгчид ашиглаж болох хариуг буцаасан байхыг;
- 1.3.5. “Төрийн цахим үйлчилгээний зохицуулатын газар” (цаашид “Агентлаг” гэх) нь үндсэн болон дэмжих системээр дамжуулан үйлчилгээ үзүүлэх гэрээг байгуулах үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх, олон нийтэд сурталчлах, сургалт зохион байгуулах, системд холбогдсон байгууллагуудын мэдээллийн системийн бэлэн байдал, гэрээний хэрэгжилтийг хангуулах төрийн захиргааны байгууллагыг;
- 1.3.6. “Үндэсний дата төв” УТҮГ” (цаашид “Дата төв” гэх) гэж үндсэн системд үйлчилгээний холболтыг хийн, ашиглах нөхцөлийг бүрдүүлж ажиллах байгууллагыг;
- 1.3.7. “И-Монгол академи” УТҮГ” (цаашид “Академи” гэх) гэж үндсэн системийн хөгжүүлэлтийг хийн, ашиглах нөхцөлийг бүрдүүлж ажиллах байгууллагыг.

Хоёр.Талуудын эрх, үүрэг

2.1. Яам нь “Үндсэн системийн үйл ажиллагааг зохицуулах, систем ашиглаж үйлчилгээ үзүүлэх, мэдээлэл солилцох журам”, “Үндсэн болон дэмжих систем ашиглан үйлчилгээ үзүүлэх гэрээний загвар, зардал тооцох аргачлал, гэрээ байгуулах журам”-д зааснаас гадна дараахь эрх, үүрэгтэй:

- 2.1.1. Гэрээний хэрэгжилтийн дүгнэх, хэрэгжилтийг сайжруулах талаар гэрээний нөгөө тал болон агентлаг, дата төв, академид зөвлөмж, чиглэл хүргүүлэх;
- 2.1.2. Үндсэн болон дэмжих системээр дамжуулан хүн, хуулийн этгээдэд үйлчилгээ үзүүлэх үйл ажиллагааг нэгдсэн зохион байгуулалтаар хангаж, хяналт тавих;
- 2.1.3. Үндсэн болон дэмжих системтэй холбоотой гаргасан хүсэлтийг хүлээн авах, бүртгэх, шийдвэрлэх, эрх бүхий байгууллагад шилжүүлж шийдвэрлүүлэх;
- 2.1.4. Үндсэн болон дэмжих системийн үйлчилгээ үзүүлэх, тайлагнах үйл ажиллагааг нэгдсэн зохион байгуулалтаар хангах;
- 2.1.5. Үндсэн болон дэмжих системээр үзүүлж буй үйлчилгээтэй холбоотой асуудлаар зөвлөгөө, мэдээлэл өгөх;
- 2.1.6. Үндсэн болон дэмжих системээр мэдээлэл солилцох холболт, техникийн хэвийн үйл ажиллагааг хангах;
- 2.1.7. Үндсэн болон дэмжих систем, сүлжээнд техникийн үзлэг, шалгалтын улмаас түр зогсолт хийх, гэмтэл, саатал гарсан тохиолдолд шаардлагатай арга хэмжээг авч хэрэгжүүлэх;
- 2.1.8. Үндсэн болон дэмжих системийн түүхчилсэн бүртгэлийг хөтлөх, төлбөр тооцохтой холбоотой үйл ажиллагааг хариуцах;
- 2.1.9. Техникийн нөхцөл, шаардлагын дагуу үндсэн болон дэмжих системийн хөгжүүлэлтийг хийх, үйлчилгээг байршуулах;

2.1.10. Үндсэн системд мэдээлэл нийлүүлэх, байршуулах талаар мэдээлэл заавар, зөвлөмж гаргах;

2.1.11. Гэрээ байгуулсан хуулийн этгээдэд гэрээнд заасан үүргээ биелүүлэх талаар шаардлага тавих, гарсан зөрчлийг арилгуулах;

2.1.12. Хэрэглэгчийн ашиглаж байгаа систем, сүлжээнд техникийн үзлэг, шалгалт хийх, техникийн нөхцөл, шаардлагыг хангаж байгаа эсэхийг дүгнэх, зөвлөмж хүргүүлэх;

2.2. Агентлаг нь гэрээний 2.1.3, 2.1.4, 2.1.5, 2.1.11 -т заасан үүргийг, Дата төв нь 2.1.6, 2.1.7, 2.1.8, 2.1.11, 2.1.12. -т заасан үүргийг, Академи нь энэ гэрээний 2.1.9, 2.1.10, 2.1.12.-т заасан үүргийг тус тус хэрэгжүүлнэ.

2.3. Хэрэглэгч нь “Үндсэн системийн үйл ажиллагааг зохицуулах, систем ашиглаж үйлчилгээ үзүүлэх, мэдээлэл солилцох журам”, Үндсэн болон дэмжих систем ашиглан үйлчилгээ үзүүлэх гэрээний загвар, зардал тооцох аргачлал, гэрээ байгуулах журам”-д зааснаас гадна дараахь эрх, үүрэгтэй:

2.3.1. Хяналтын системд хэрэглэгчийн бүртгэл үүсгүүлэх, хэрэглэгч өөрчлөгдсөн тохиолдолд тухай бүр мэдэгдэж, шинэчлүүлэх;

2.3.2. Өөрийн хариуцан ажиллаж байгаа сервер болон мэдээллийн сангийн тасалдалгүй найдвартай ажиллагааг хангах;

2.3.3. Үндсэн болон дэмжих системийн техникийн нөхцөл, шаардлагыг хангах талаар гарсан аливаа доголдлыг шийдвэрлүүлэх;

2.3.4. Тасалдал, саатлыг бүртгэгдсэнээс хойш нэн даруй арга хэмжээ авах;

2.3.5. Үндсэн системд нийлүүлж байгаа мэдээлэлд (API) өөрчлөлт оруулахын өмнө мэдэгдэх;

2.3.6. “ХУР” системээс авч байгаа мэдээллийг хуульд заасан үндэслэл, журмын дагуу ашиглах;

2.3.7. Мэдээллийн эзний зөвшөөрлийн үндсэн дээр хязгаарлалттай мэдээллийг ашиглах, мэдээллийг мэдээллийн эзний зөвшөөрөлгүйгээр бусдад дамжуулахгүй, задруулахгүй байх;

2.3.8. Үндсэн болон дэмжих системд холбогдсон системийг шинэчлэх, холбогдох туршилт хийх тухай бүр үйлчилгээ үзүүлэгч байгуулагад урьдчилан мэдэгдэх;

2.3.9. Системд холбогдон үйлчилгээ авахад ашиглаж буй токен, нэвтрэх эрхийг бусдад ашиглуулахгүй байх;

2.3.10. Гэрээ цуцлах, гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулах саналыг хүргүүлэх.

Гурав.Гэрээний хугацаа

3.1. Үндсэн систем болон дэмжих системээс үйлчилгээ үзүүлэх гэрээний хугацаа 3 жил байна.

3.2. Хэрэглэгч энэ гэрээний 3.1-д заасан хугацааг сунгах тухай хүсэлт ирүүлээгүй тохиолдолд гэрээг анх байгуулсан хугацаагаар сунгагдсанд тооцно.

3.3. Гэрээ байгуулсанаас хойш үйлчилгээ нэмж авах тохиолдолд нэмэлт гэрээ байгуулна.

Дөрөв.Гэрээний төлбөр

4.1. Дата төв “Үндсэн болон дэмжих систем ашиглан үйлчилгээ үзүүлэх гэрээний загвар, зардал тооцох аргачлал, гэрээ байгуулах журам”-ын 1.2-т заасны дагуу тооцсон гэрээний төлбөрийг сар бүрийн 1-ний өдрөөс тухайн сарын сүүлийн өдрөөр тасалбар болгон дараа сарын 10-ны өдрийн дотор нэхэмжилнэ.

4.2.Хэрэглэгч нь тухайн сарын төлбөрийг дараа сарын 20-ны өдрийн дотор Дата төвийн _____ тоот дансанд шилжүүлнэ.

Тав.Давагдашгүй хүчин зүйлс

5.1.“Давагдашгүй хүчин зүйлс” гэж гэрээний талууд урьдчилан таамаглаагүй, мэдэх боломжгүй буюу түүнийг шийдвэрлэхэд бэрхшээлтэй нөхцөл байдал, гал түймэр, газар хөдлөлт, салхи шуурга, аянга цахилгаан, үер усны зэрэг байгалийн гамшиг, нийтийг хамарсан эмх замбараагүй байдал, үймээн самуун, ажил хаялт, гоц халдварт өвчин, цар тахал дэлгэрэх, улс орныг хамарсан онц бөгөөд дайн бүхий байдал үүсэх, террорист халдлага, төрийн эрх бүхий байгууллагын шийдвэр, хорио цээрийн дэглэм тогтоох, удаан хугацааны эрчим хүчний тасалдал зэрэг талуудын санаа зоригоос гадуур үүсэж болох нөхцөлүүдийг ойлгоно.

5.2. Давагдашгүй хүчин зүйлсийн улмаас талуудын аль нэг тал нь гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэх боломжгүй болсон тохиолдолд гэрээний нөгөө талд ажлын 3 өдрийн дотор мэдэгдэх ба үүрэг хүлээх хугацаа нь тухайн нөхцөл байдал үргэлжлэх хугацаагаар хойшлогдоно.

5.3.Давагдашгүй хүчин зүйл үүссэн тохиолдолд гуравдагч этгээд буюу эрх бүхий байгууллагаас нотолсон баримтыг гаргуулж авна.

5.4.Давагдашгүй хүчин зүйл бий болсон нь хуанлийн нэг сараас дээш хугацаагаар үргэлжилбэл талууд асуудлыг харилцан зөвшилцөх замаар шийдвэрлэнэ.

Зургаа.Талуудын хүлээх хариуцлага

6.1. Талууд энэ гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүйгээс үүссэн аливаа хохирлыг хариуцан, гэрээний нөгөө талд барагдуулна.

6.2. Хэрэглэгч нь энэ гэрээнд заасан төлбөр төлөх хугацааг хэтрүүлсэн тохиолдолд Дата төв үйлчилгээний хандах эрхийг түр хугацаагаар хязгаарлана.

Долоо.Гэрээнээс үүдэлтэй маргаан шийдвэрлэх

7.1. Гэрээний талууд гэрээнээс үүссэн аливаа маргааныг үл маргах буюу харилцан зөвшилцөх замаар шийдвэрлэхийг эрмэлзэнэ.

7.2. Гэрээний талууд харилцан зөвшилцөж чадаагүй тохиолдолд хуульд заасан журмын дагуу шүүхэд хандаж шийдвэрлүүлнэ.

Найм.Бусад зүйлс

8.1.Талууд нь энэ гэрээний 2.2-т зааснаас бусад үүргээ гуравдагч этгээдэд хэсэгчлэн болон бүрэн хэмжээгээр шилжүүлэхгүй.

8.2. Аль нэг тал нь уг гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулах, гэрээг цуцлах саналыг нөгөө талдаа урьдчилан мэдэгдэж хамтран шийдвэрлэнэ.

8.3. Энэ гэрээг талууд тоон гарын үсгээр баталгаажуулснаар хүчин төгөлдөр болох ба гэрээг 2 хувь үйлдэж, тус бүр нэг хувийг хадгалах бөгөөд хувь тус бүр хууль зүйн хувьд ижил хүчинтэй байна.

Ес. Гэрээний хавсралт

9.1. Доорх хавсралт нь гэрээний салшгүй хэсэг байна.

9.1.1. хавсралт: “_____”-ийн _____ “ХҮР” системээр дамжуулан хүлээн авах мэдээлэл _____ хуудас.

Талуудын хаяг:

Хаяг: Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Энхтайвны өргөн чөлөө, Сүхбаатарын талбай-1, Төв шуудан, Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яам.

Утас: +976-11330781

Факс:

Цахим хуудас: www.mddic.gov.mn

Цахим шуудан: info@mddic.gov.mn

Хаяг:

Утас:

Факс:

Цахим хуудас:

Цахим шуудан:

Гэрээ байгуулсан:

Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яамыг төлөөлж:

..... (албан тушаал)

..... (эцэг/эх/-ийн нэр, нэр)

..... (албан тушаал)

..... (эцэг/эх/-ийн нэр, нэр)

..... (албан тушаал)

..... (эцэг/эх/-ийн нэр, нэр)

(тамга, тэмдэг)

.....: төлөөлж:

.....

.....

(тамга, тэмдэг)

Журмын 1 дүгээр хавсралтаар баталсан
гэрээний загварын хавсралт

“.....”-ИЙН “ХҮР” СИСТЕМЭЭР ДАМЖУУЛАН ХҮЛЭЭН АВАХ
МЭДЭЭЛЭЛ

[illegible]

“Үндсэн болон дэмжих систем ашиглан
үйлчилгээ үзүүлэх гэрээний загвар, зардал
тооцох аргачлал, гэрээ байгуулах журам”-ын
2 дугаар хавсралт

БАТЛАВ.

БАТЛАВ.

ТАНИЛТ, НЭВТРЭЛТИЙН СИСТЕМ АШИГЛАН ҮЙЛЧИЛГЭЭ ҮЗҮҮЛЭХ ГЭРЭЭНИЙ ЗАГВАР

№ ...

Энэхүү гэрээг нэг талаас Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яам
(цаашид “яам” гэх), түүнийг төлөөлж

(албан тушаал, эцэг/эх/-ийн нэр, нэр),

Нөгөө талаас _____
(цаашид “Хэрэглэгч” гэх), түүнийг төлөөлж _____
(албан тушаал, эцэг/эх/-ийн нэр, нэр)

нар (хамтад нь “Талууд” гэх) дор дурдсан нөхцөлийг харилцан тохиролцож гэрээг
байгуулав.

Нэг.Нийтлэг үндэслэл

1.1. Талууд гэрээгээр хүлээсэн үүргээ хэрэгжүүлэхдээ Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хууль, Цахим гарын үсгийн тухай хууль, Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хууль, “И-Монгол академи” улсын төсөвт үйлдвэрийн газрын дүрэм, “Үндэсний дата төв” улсын төсөвт үйлдвэрийн газрын дүрэм, “Үндсэн системийн үйл ажиллагааг зохицуулах, систем ашиглаж үйлчилгээ үзүүлэх, мэдээлэл солилцох журам”, “Үндсэн болон дэмжих систем ашиглан үйлчилгээ үзүүлэх гэрээний загвар, зардал тооцох аргачлал, гэрээ байгуулах журам”, Үндсэн систем, дэмжих системийн техникийн нөхцөл, шаардлага, заавар, аргачлал болон бусад холбогдох хууль тогтоомж, эрх зүйн актыг дагаж мөрдөнө.

1.2. Энэ гэрээгээр хэрэглэгчийг Танилт, нэвтрэлтийн системд холбож, гэрээний хавсралтад заасан мэдээллийг дамжуулах үед үүсэх харилцааг зохицуулна.

1.3. Энэ гэрээнд хэрэглэсэн дараахь нэр томъёог дор дурдсан утгаар ойлгоно:

1.3.1. “Танилт, нэвтрэлтийн систем” гэж үндсэн болон Хэрэглэгчийн системийн хэвийн, найдвартай, аюулгүй ажиллагааг хангах зорилго бүхий бие даасан системийг;

1.3.2. “Хэрэглэгч” гэж гэрээ байгуулан үндсэн болон дэмжих систем ашиглаж байгаа төрийн байгууллага, хуулийн этгээдийг;

1.3.3. “Төрийн цахим үйлчилгээний зохицуулатын газар” (цаашид “Агентлаг” гэх) нь үндсэн болон дэмжих системээр дамжуулан үйлчилгээ үзүүлэх гэрээг байгуулах үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх, олон нийтэд сурталчлах,

сургалт зохион байгуулах, системд холбогдсон байгууллагуудын мэдээллийн системийн бэлэн байдал, гэрээний хэрэгжилтийг хангуулах төрийн захиргааны байгууллагыг;

1.3.4. “Үндэсний дата төв” УТҮГ” (цаашид “Дата төв” гэх) гэж үндсэн системд үйлчилгээний холболтыг хийн, ашиглах нөхцөлийг бүрдүүлж ажиллах байгууллагыг;

1.3.5. “И-Монгол академи” УТҮГ” (цаашид “Академи” гэх) гэж үндсэн системийн хөгжүүлэлтийг хийн, ашиглах нөхцөлийг бүрдүүлж ажиллах байгууллагыг.

1.3.6. “Амжилттай дуудсан сервис” гэж тухайн сервисийг дуудаж байгаа хэрэглэгчид ашиглаж болох хариу буцаасан байхыг.

Хоёр.Талуудын эрх, үүрэг

2.1. Яам нь “Үндсэн системийн үйл ажиллагааг зохицуулах, систем ашиглаж үйлчилгээ үзүүлэх, мэдээлэл солилцох журам”, “Үндсэн болон дэмжих систем ашиглан үйлчилгээ үзүүлэх гэрээний загвар, зардал тооцох аргачлал, гэрээ байгуулах журам”-д зааснаас гадна дараахь эрх, үүрэгтэй:

2.1.1. Гэрээний хэрэгжилтийн дүгнэх, хэрэгжилтийг сайжруулах талаар гэрээний нөгөө тал болон агентлаг, дата төв, академид зөвлөмж, чиглэл хүргүүлэх;

2.1.2. Үндсэн болон дэмжих системээр дамжуулан хүн, хуулийн этгээдэд үйлчилгээ үзүүлэх үйл ажиллагааг нэгдсэн зохион байгуулалтаар хангаж, хяналт тавих;

2.1.3. Үндсэн болон дэмжих системтэй холбоотой гаргасан хүсэлтийг хүлээн авах, бүртгэх, шийдвэрлэх, эрх бүхий байгууллагад шилжүүлж шийдвэрлүүлэх;

2.1.4. Үндсэн болон дэмжих системийн үйлчилгээ үзүүлэх, тайлагнах үйл ажиллагааг нэгдсэн зохион байгуулалтаар хангах;

2.1.5. Үндсэн болон дэмжих системээр үзүүлж буй үйлчилгээтэй холбоотой асуудлаар зөвлөгөө, мэдээлэл өгөх;

2.1.6. Үндсэн болон дэмжих системээр мэдээлэл солилцох холболт, техникийн хэвийн үйл ажиллагааг хангах;

2.1.7. Үндсэн болон дэмжих систем, сүлжээнд техникийн үзлэг, шалгалтын улмаас түр зогсолт хийх, гэмтэл, саатал гарсан тохиолдолд шаардлагатай арга хэмжээг авч хэрэгжүүлэх;

2.1.8. Үндсэн болон дэмжих системийн түүхчилсэн бүртгэлийг хөтлөх, төлбөр тооцохтой холбоотой үйл ажиллагааг хариуцах;

2.1.9. Техникийн нөхцөл, шаардлагын дагуу үндсэн болон дэмжих системийн хөгжүүлэлтийг хийх, үйлчилгээг байршуулах;

2.1.10. Үндсэн системд мэдээлэл нийлүүлэх, байршуулах талаар мэдээлэл заавар, зөвлөмж гаргах;

2.1.11. Гэрээ байгуулсан хуулийн этгээдэд гэрээнд заасан үүргээ биелүүлэх талаар шаардлага тавих, гарсан зөрчлийг арилгуулах;

2.1.12. Хэрэглэгчийн ашиглаж байгаа систем, сүлжээнд техникийн үзлэг, шалгалт хийх, техникийн нөхцөл, шаардлагыг хангаж байгаа эсэхийг дүгнэх, зөвлөмж хүргүүлэх;

2.2. Агентлаг нь гэрээний 2.1.3, 2.1.4, 2.1.5, 2.1.11 -т заасан үүргийг, Дата төв нь 2.1.6, 2.1.7, 2.1.8, 2.1.11, 2.1.12. -т заасан үүргийг, Академи нь энэ гэрээний 2.1.9, 2.1.10, 2.1.12.-т заасан үүргийг тус тус хэрэгжүүлнэ.

2.3. Хэрэглэгч нь “Үндсэн системийн үйл ажиллагааг зохицуулах, систем ашиглаж үйлчилгээ үзүүлэх, мэдээлэл солилцох журам”, Үндсэн болон дэмжих систем ашиглан үйлчилгээ үзүүлэх гэрээний загвар, зардал тооцох аргачлал, гэрээ байгуулах журам”-д зааснаас гадна дараахь эрх, үүрэгтэй:

2.3.1. Хяналтын системд хэрэглэгчийн бүртгэл үүсгүүлэх, хэрэглэгч өөрчлөгдсөн тохиолдолд тухай бүр мэдэгдэж, шинэчлүүлэх;

2.3.2. Өөрийн хариуцан ажиллаж байгаа сервер болон мэдээллийн сангийн тасалдалгүй найдвартай ажиллагааг хангах;

2.3.3. Үндсэн болон дэмжих системийн техникийн нөхцөл, шаардлагыг хангах талаар гарсан аливаа доголдлыг шийдвэрлүүлэх;

2.3.4. Тасалдал, саатлыг бүртгэгдсэнээс хойш нэн даруй арга хэмжээ авах;

2.3.5. Шаардлагатай тохиолдолд танилт, нэвтрэлтийн системд иргэнийг таних үед Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 19.1-д заасны дагуу ашигласан танилт, нэвтрэлтийн арга хэрэгслээр үйлчилгээний цар хүрээг хязгаарлах;

2.3.6. “ХУР” системээс авч байгаа мэдээллийг хуульд заасан үндэслэл, журмын дагуу ашиглах;

2.3.7. Танилт, нэвтрэлтийн системд холбогдсон системийг шинэчлэх, холбогдох туршилт хийх тухай бүр үйлчилгээ үзүүлэгч байгуулагад урьдчилан мэдэгдэх;

2.3.8. Танилт, нэвтрэлтийн системд холбогдон үйлчилгээ авахад ашиглаж буй токен, нэвтрэх эрхийг бусдад ашиглуулахгүй байх;

2.3.9. Гэрээ цуцлах, гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулах саналыг хүргүүлэх.

Гурав.Гэрээний хугацаа

3.1. Үндсэн систем болон дэмжих системээс үйлчилгээ үзүүлэх гэрээний хугацаа 3 жил байна.

3.2. Хэрэглэгч энэ гэрээний 3.1-д заасан хугацааг сунгах тухай хүсэлт ирүүлээгүй тохиолдолд гэрээг анх байгуулсан хугацаагаар сунгагдсанд тооцно.

3.3. Гэрээ байгуулсанаас хойш үйлчилгээ нэмж авах тохиолдолд нэмэлт гэрээ байгуулна.

Дөрөв.Гэрээний төлбөр

4.1. Дата төв “Үндсэн болон дэмжих систем ашиглан үйлчилгээ үзүүлэх гэрээний загвар, зардал тооцох аргачлал, гэрээ байгуулах журам”-ын 1.2-т заасны дагуу тооцсон гэрээний төлбөрийг сар бүрийн 1-ний өдрөөс тухайн сарын сүүлийн өдрөөр тасалбар болгон дараа сарын 10-ны өдрийн дотор нэхэмжилнэ.

4.2.Хэрэглэгч нь тухайн сарын төлбөрийг дараа сарын 20-ны өдрийн дотор Дата төвийн _____ тоот дансанд шилжүүлнэ.

Тав.Давагдашгүй хүчин зүйлс

5.1.“Давагдашгүй хүчин зүйлс” гэж гэрээний талууд урьдчилан таамаглаагүй, мэдэх боломжгүй буюу түүнийг шийдвэрлэхэд нэн бэрхшээлтэй нөхцөл байдал, гал түймэр, газар хөдлөлт, салхи шуурга, аянга цахилгаан, үер усны зэрэг байгалийн гамшиг, нийтийг хамарсан эмх замбараагүй байдал, үймээн самуун, ажил хаялт, гоц халдварт өвчин, цар тахал дэлгэрэх, улс орныг хамарсан онц бөгөөд дайн бүхий байдал үүсэх, террорист халдлага, төрийн эрх бүхий байгууллагын шийдвэр, хорио цээрийн дэглэм тогтоох, удаан хугацааны эрчим хүчний тасалдал зэрэг талуудын санаа зоригоос гадуур үүсэж болох нөхцөлүүдийг ойлгоно.

5.2. Давагдашгүй хүчин зүйлсийн улмаас талуудын аль нэг тал нь гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэх боломжгүй болсон тохиолдолд гэрээний нөгөө талд ажлын 3 өдрийн дотор мэдэгдэх ба үүрэг хүлээх хугацаа нь тухайн нөхцөл байдал үргэлжлэх хугацаагаар хойшлогдоно.

5.3. Давагдашгүй хүчин зүйл үүссэн тохиолдолд гуравдагч этгээд буюу эрх бүхий байгууллагаас нотолсон баримтыг гаргуулж авна.

5.4.Давагдашгүй хүчин зүйл бий болсон нь хуанлийн нэг сараас дээш хугацаагаар үргэлжилбэл талууд асуудлыг харилцан зөвшилцөх замаар шийдвэрлэнэ.

Зургаа.Талуудын хүлээх хариуцлага

6.1.Талууд гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүйгээс үүссэн аливаа хохирлыг хариуцан, гэрээний нөгөө талд барагдуулна.

6.2.Хэрэглэгч нь гэрээнд заасан төлбөр төлөх хугацааг хэтрүүлсэн тохиолдолд Академи нь үйлчилгээний хандах эрхийг түр хугацаагаар хязгаарлана.

Долоо.Гэрээнээс үүдэлтэй маргаан шийдвэрлэх

7.1.Гэрээнээс үүссэн аливаа маргааныг үл маргах буюу харилцан зөвшилцөх замаар шийдвэрлэхийг эрмэлзэнэ.

7.2.Гэрээний талууд харилцан зөвшилцөж чадаагүй тохиолдолд хуульд заасан журмын дагуу шүүхэд хандаж шийдвэрлүүлнэ.

Найм.Бусад зүйлс

8.1.Талууд нь энэ гэрээний 2.2-т зааснаас бусад үүргээ гуравдагч этгээдэд хэсэгчлэн болон бүрэн хэмжээгээр шилжүүлэхгүй.

8.2. Аль нэг тал нь уг гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулах, гэрээг цуцлах саналыг нөгөө талдаа урьдчилан мэдэгдэж хамтран шийдвэрлэнэ.

8.3.Энэ гэрээг талууд тоон гарын үсгээр баталгаажуулснаар хүчин төгөлдөр болох ба гэрээг 2 хувь үйлдэж, тус бүр нэг хувийг хадгалах бөгөөд хувь тус бүр хууль зүйн хувьд ижил хүчинтэй байна.

Ес.Гэрээний хавсралт

9.1.Доорх хавсралт нь гэрээний салшгүй хэсэг байна.

9.1.1.хавсралт: “_____”-ийн _____“ХҮР” системээр дамжуулан хүлээн авах мэдээлэл _____хуудас.

Талуудын хаяг:

Хаяг: Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Энхтайвны өргөн чөлөө, Сүхбаатарын талбай-1, Төв шуудан, Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яам.

Утас: +976-11330781

Факс:

Цахим хуудас: www.mddic.gov.mn

Цахим шуудан: info@mddic.gov.mn

Хаяг:

Утас:

Факс:

Цахим хуудас:

Цахим шуудан:

Гэрээ байгуулсан:

Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яамыг төлөөлж:

..... (албан тушаал)

..... (эцэг/эх/-ийн нэр, нэр)

..... (албан тушаал)

.....(эцэг/эх/-ийн нэр, нэр)

..... (албан тушаал)

.....(эцэг/эх/-ийн нэр, нэр)

(тамга, тэмдэг)

.....: төлөөлж:

.....

.....

(тамга, тэмдэг)

Журмын 2 дугаар хавсралтаар баталсан
гэрээний загварын хавсралт

“.....” –ИЙН ДОМЭЙНД “ХУР” СИСТЕМЭЭР ДАМЖУУЛАН
ХҮЛЭЭН АВАХ МЭДЭЭЛЭЛ

[illegible]

“Үндсэн болон дэмжих систем ашиглан үйлчилгээ үзүүлэх гэрээний загвар, зардал тооцох аргачлал, гэрээ байгуулах журам”-ын 3 дугаар хавсралт

БАТЛАВ.

БАТЛАВ.

АЛБАН БИЧИГ СОЛИЛЦООНЫ ДУНДЫН СИСТЕМ АШИГЛАН
ҮЙЛЧИЛГЭЭ ҮЗҮҮЛЭХ ГЭРЭЭНИЙ ЗАГВАР

№ ...

2025 оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар хот

Энэхүү гэрээг нэг талаас Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны
яам (цаашид “яам” гэх), түүнийг төлөөлж

(албан тушаал, эцэг/эх/-ийн нэр, нэр),

Нөгөө талаас _____
(цаашид “Хэрэглэгч” гэх), түүнийг төлөөлж _____
(албан тушаал, эцэг/эх/-ийн нэр, нэр)

нар (хамтад нь “Талууд” гэх) дор дурдсан нөхцөлийг харилцан тохиролцож гэрээг байгуулав.

Нэг.Нийтлэг үндэслэл

1.1. Талууд гэрээгээр хүлээсэн үүргээ хэрэгжүүлэхдээ Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хууль, Цахим гарын үсгийн тухай хууль, Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хууль, “И-Монгол академи” улсын төсөвт үйлдвэрийн газрын дүрэм, “Үндсэн системийн үйл ажиллагааг зохицуулах, систем ашиглаж үйлчилгээ үзүүлэх, мэдээлэл солилцох журам”, “Үндсэн болон дэмжих систем ашиглан үйлчилгээ үзүүлэх гэрээний загвар, зардал тооцох аргачлал, гэрээ байгуулах журам”, Үндсэн систем, дэмжих системийн техникийн нөхцөл, шаардлага, заавар, аргачлал болон бусад холбогдох хууль тогтоомж, эрх зүйн актыг дагаж мөрдөнө.

1.2. Энэ гэрээгээр хэрэглэгчийг Албан бичиг солилцооны дундын системд холболт хийх үед үүсэх харилцааг зохицуулна.

1.3.Энэ гэрээнд хэрэглэсэн дараахь нэр томъёог дор дурдсан утгаар ойлгоно:

1.3.1.“Албан бичиг солилцооны дундын систем” гэж Хэрэглэгч хоорондоо албаны цахим шуудангаас бусад хэлбэрээр цахимаар албан бичиг илгээх, хүлээн авахдаа ашиглах боломж бүхий системийг;

1.3.2.“Хэрэглэгч” гэж гэрээ байгуулан үндсэн болон дэмжих систем ашиглаж байгаа төрийн байгууллага, хуулийн этгээдийг;

1.3.3.“И-Монгол академи” УТҮГ” (цаашид “Академи” гэх) гэж Албан бичиг солилцооны дундын системийн хөгжүүлэлтийг хийн, ашиглах нөхцөлийг бүрдүүлж ажиллах байгууллагыг;

1.3.5.“Тоон гарын үсэг” гэж Цахим гарын үсгийн тухай хуулийн 4.1.2-т заасныг;

1.3.6.“Дотоод удирдлагын систем” гэж хэрэглэгч байгууллагын ашигладаг албан бичиг цахимаар солилцох системийг;

1.3.7.“Хэрэглэгчийн токен” гэж албан бичиг солилцооны дундын системд холбогдох үед үүсгэж өгсөн мэдээллийг.

1.3.8.“Амжилттай дуудсан сервис” гэж тухайн сервисийг дуудаж байгаа хэрэглэгчид ашиглаж болох хариу буцаасан байхыг.

Хоёр.Талуудын эрх, үүрэг

2.1. Яам нь “Үндсэн системийн үйл ажиллагааг зохицуулах, систем ашиглаж үйлчилгээ үзүүлэх, мэдээлэл солилцох журам”, “Үндсэн болон дэмжих систем ашиглан үйлчилгээ үзүүлэх гэрээний загвар, зардал тооцох аргачлал, гэрээ байгуулах журам”-д зааснаас гадна дараахь эрх, үүрэгтэй:

2.1.1. Гэрээний хэрэгжилтийн дүгнэх, хэрэгжилтийг сайжруулах талаар гэрээний нөгөө тал болон Агентлаг, Академид зөвлөмж, чиглэл хүргүүлэх;

2.1.2. Үндсэн болон дэмжих системээр дамжуулан хүн, хуулийн этгээдэд үйлчилгээ үзүүлэх үйл ажиллагааг нэгдсэн зохион байгуулалтаар хангаж, хяналт тавих;

2.1.3. Үндсэн болон дэмжих системтэй холбоотой гаргасан хүсэлтийг хүлээн авах, бүртгэх, шийдвэрлэх, эрх бүхий байгууллагад шилжүүлж шийдвэрлүүлэх;

2.1.4. Үндсэн болон дэмжих системийн үйлчилгээ үзүүлэх, тайлагнах үйл ажиллагааг нэгдсэн зохион байгуулалтаар хангах;

2.1.5. Үндсэн болон дэмжих системээр үзүүлж буй үйлчилгээтэй холбоотой асуудлаар зөвлөгөө, мэдээлэл өгөх;

2.1.6. Үндсэн болон дэмжих системээр мэдээлэл солилцох холболт, техникийн хэвийн үйл ажиллагааг хангах;

2.1.7. Үндсэн болон дэмжих систем, сүлжээнд техникийн үзлэг, шалгалтын улмаас түр зогсолт хийх, гэмтэл, саатал гарсан тохиолдолд шаардлагатай арга хэмжээг авч хэрэгжүүлэх;

2.1.8 Албан бичиг солилцооны дундын системийн түүхчилсэн бүртгэлийг хөтлөх, төлбөр тооцохтой холбоотой үйл ажиллагааг хариуцах;

2.1.9. Албан бичиг солилцооны дундын системд хэрэглэгч байгууллагыг холбож, хэрэглэгчийн токеныг үүсгэн хамтын ажиллагаа хариуцсан ажилтанд нууцлалтайгаар илгээх;

2.1.10. Хэрэглэгчийн дотоод удирдлагын системд хэрэглэгчийн токеныг оруулж, албан бичиг солилцооны дундын системд холбогдох зааварчилгааг өгөх;

2.1.11. Албан бичиг солилцооны дундын системийн ашиглалт, үйлчилгээний аюулгүй байдал, тогтвортой ажиллагааны нөхцөлийг хангах;

2.1.12. Албан бичиг солилцооны дундын системийн хөгжүүлэлтийг хариуцах;

2.1.13. Гэрээ байгуулсан хуулийн этгээдэд гэрээнд заасан үүргээ биелүүлэх талаар шаардлага тавих, гарсан зөрчлийг арилгуулах;

2.2. Агентлаг нь гэрээний 2.1.3, 2.1.4, 2.1.5, 2.1.13 -т заасан үүргийг, Академи нь энэ гэрээний 2.1.6, 2.1.7, 2.1.8, 2.1.9, 2.1.10, 2.1.11, 2.1.12, 2.1.13-т заасан үүргийг тус тус хэрэгжүүлнэ.

2.3. Хэрэглэгч нь “Үндсэн системийн үйл ажиллагааг зохицуулах, систем ашиглаж үйлчилгээ үзүүлэх, мэдээлэл солилцох журам”, Үндсэн болон дэмжих систем ашиглан үйлчилгээ үзүүлэх гэрээний загвар, зардал тооцох аргачлал, гэрээ байгуулах журам”-д зааснаас гадна дараахь эрх, үүрэгтэй:

2.3.1. Үндсэн болон дэмжих системийн техникийн нөхцөл, шаардлагыг хангах талаар гарсан аливаа доголдлыг шийдвэрлүүлэх;

2.3.2. Тасалдал, саатлыг бүртгэгдсэнээс хойш нэн даруй арга хэмжээ авах;

2.3.3. Танилт, нэвтрэлтийн системд холбогдсон системийг шинэчлэх, холбогдох туршилт хийх тухай бүр үйлчилгээ үзүүлэгч байгууллагад урьдчилан мэдэгдэх;

2.3.4. Академиас илгээсэн хэрэглэгчийн токеныг нууцлалыг хангах, дотоод удирдлагын системээс бусад системд ашиглаж, дамжуулахгүй байх;

2.3.5. Гэрээ цуцлах, гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулах саналыг хүргүүлэх.

Гурав.Гэрээний хугацаа

3.1. Үндсэн систем болон дэмжих системээс үйлчилгээ үзүүлэх гэрээний хугацаа 3 жил байна.

3.2. Хэрэглэгч энэ гэрээний 3.1-д заасан хугацааг сунгах тухай хүсэлт ирүүлээгүй тохиолдолд гэрээг анх байгуулсан хугацаагаар сунгагдсанд тооцно.

3.3. Гэрээ байгуулсанаас хойш үйлчилгээ нэмж авах тохиолдолд нэмэлт гэрээ байгуулна.

Дөрөв.Гэрээний төлбөр

4.1. Академи “Үндсэн болон дэмжих систем ашиглан үйлчилгээ үзүүлэх гэрээний загвар, зардал тооцох аргачлал, гэрээ байгуулах журам”-ын 1.2-т заасны дагуу тооцсон гэрээний төлбөрийг сар бүрийн 1-ний өдрөөс тухайн сарын сүүлийн өдрөөр тасалбар болгон дараа сарын 10-ны өдрийн дотор нэхэмжилнэ.

4.2.Хэрэглэгч нь тухайн сарын төлбөрийг дараа сарын 20-ны өдрийн дотор Академийн_____ тоот дансанд шилжүүлнэ.

Тав.Давагдашгүй хүчин зүйлс

5.1.“Давагдашгүй хүчин зүйлс” гэж гэрээний талууд урьдчилан таамаглаагүй, мэдэх боломжгүй буюу түүнийг шийдвэрлэхэд нэн бэрхшээлтэй нөхцөл байдал, гал

түймэр, газар хөдлөлт, салхи шуурга, аянга цахилгаан, үер усны зэрэг байгалийн гамшиг, нийтийг хамарсан эмх замбараагүй байдал, үймээн самуун, ажил хаялт, гоц халдварт өвчин, цар тахал дэлгэрэх, улс орныг хамарсан онц бөгөөд дайн бүхий байдал үүсэх, террорист халдлага, төрийн эрх бүхий байгууллагын шийдвэр, хорио цээрийн дэглэм тогтоох, удаан хугацааны эрчим хүчний тасалдал зэрэг талуудын санаа зоригоос гадуур үүсэж болох нөхцөлүүдийг ойлгоно.

5.2.Давагдашгүй хүчин зүйлсийн улмаас талуудын аль нэг тал нь гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэх боломжгүй болсон тохиолдолд гэрээний нөгөө талд ажлын 3 өдрийн дотор мэдэгдэх ба үүрэг хүлээх хугацаа нь тухайн нөхцөл байдал үргэлжлэх хугацаагаар хойшлогдоно.

5.3.Давагдашгүй хүчин зүйл үүссэн тохиолдолд гуравдагч этгээд буюу эрх бүхий байгууллагаас нотолсон баримтыг гаргуулж авна.

5.4.Давагдашгүй хүчин зүйл бий болсон нь хуанлийн нэг сараас дээш хугацаагаар үргэлжилбэл талууд асуудлыг харилцан зөвшилцөх замаар шийдвэрлэнэ.

Зургаа.Талуудын хүлээх хариуцлага

6.1.Талууд гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүйгээс үүссэн аливаа хохирлыг хариуцан, гэрээний нөгөө талд барагдуулна.

6.2.Хэрэглэгч нь гэрээнд заасан төлбөр төлөх хугацааг хэтрүүлсэн тохиолдолд Академи нь үйлчилгээний хандах эрхийг түр хугацаагаар хязгаарлана.

Долоо.Гэрээнээс үүдэлтэй маргаан шийдвэрлэх

7.1.Гэрээнээс үүссэн аливаа маргааныг үл маргах буюу харилцан зөвшилцөх замаар шийдвэрлэхийг эрмэлзэнэ.

7.2.Гэрээний талууд харилцан зөвшилцөж чадаагүй тохиолдолд хуульд заасан журмын дагуу шүүхэд хандаж шийдвэрлүүлнэ.

Найм.Бусад зүйлс

8.1.Талууд нь энэ гэрээний 2.2-т зааснаас бусад үүргээ гуравдагч этгээдэд хэсэгчлэн болон бүрэн хэмжээгээр шилжүүлэхгүй.

8.2. Аль нэг тал нь уг гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулах, гэрээг цуцлах саналыг нөгөө талдаа урьдчилан мэдэгдэж хамтран шийдвэрлэнэ.

8.3.Энэ гэрээг талууд тоон гарын үсгээр баталгаажуулснаар хүчин төгөлдөр болох ба гэрээг 2 хувь үйлдэж, тус бүр нэг хувийг хадгалах бөгөөд хувь тус бүр хууль зүйн хувьд ижил хүчинтэй байна.

Ес.Гэрээний хавсралт

9.1.Доорх хавсралт нь гэрээний салшгүй хэсэг байна.

9.1.1.хавсралт: “_____”-ийн _____“ХҮР” системээр
дамжуулан хүлээн авах мэдээлэл _____хуудас.

Талуудын хаяг:

Хаяг: Чингэлтэй дүүрэг, 1-р хороо,
Энхтайвны өргөн чөлөө,
Сүхбаатарын талбай-1, Төв
шуудан, Цахим хөгжил, инновац,
харилцаа холбооны яам.

Утас: +976-11330781

Факс:

Цахим хуудас: www.mddic.gov.mn

Цахим шуудан: info@mddic.gov.mn

Хаяг:

Утас:

Факс:

Цахим хуудас:

Цахим шуудан:

Гэрээ байгуулсан:

Цахим хөгжил, инновац, харилцаа
холбооны яамыг төлөөлж:

..... (албан тушаал)

..... (эцэг/эх/-ийн нэр, нэр)

..... (албан тушаал)

.....(эцэг/эх/-ийн нэр, нэр)

..... (албан тушаал)

.....(эцэг/эх/-ийн нэр, нэр)

(тамга, тэмдэг)

.....: төлөөлж:

.....

.....

(тамга, тэмдэг)

“Үндсэн болон дэмжих систем ашиглан
үйлчилгээ үзүүлэх гэрээний загвар, зардал
тооцох аргачлал, гэрээ байгуулах журам”-ын
4 дүгээр хавсралт

БАТЛАВ.

БАТЛАВ.

МЭДЭГДЭЛ ХҮРГЭХ СИСТЕМ АШИГЛАН ҮЙЛЧИЛГЭЭ ҮЗҮҮЛЭХ ГЭРЭЭНИЙ ЗАГВАР

№ ...

2025 оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар хот

Энэхүү гэрээг нэг талаас Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яам (цаашид
“яам” гэх), түүнийг төлөөлж _____
(албан тушаал, эцэг/эх/-ийн нэр, нэр),

Нөгөө талаас _____
(цаашид “Хэрэглэгч” гэх), түүнийг төлөөлж _____
(албан тушаал, эцэг/эх/-ийн нэр, нэр)
нар (хамтад нь “Талууд” гэх) дор дурдсан нөхцөлийг харилцан тохиролцож гэрээг
байгуулав.

Нэг.Нийтлэг үндэслэл

1.1. Талууд гэрээгээр хүлээсэн үүргээ хэрэгжүүлэхдээ Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хууль, Цахим гарын үсгийн тухай хууль, Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хууль, “И-Монгол академи” улсын төсөвт үйлдвэрийн газрын дүрэм, “Үндэсний дата төв” улсын төсөвт үйлдвэрийн газрын дүрэм, “Үндсэн системийн үйл ажиллагааг зохицуулах, систем ашиглаж үйлчилгээ үзүүлэх, мэдээлэл солилцох журам”, “Үндсэн болон дэмжих систем ашиглан үйлчилгээ үзүүлэх гэрээний загвар, зардал тооцох аргачлал, гэрээ байгуулах журам”, Үндсэн систем, дэмжих системийн техникийн нөхцөл, шаардлага, заавар, аргачлал болон бусад холбогдох хууль тогтоомж, эрх зүйн актыг дагаж мөрдөнө.

1.2.Энэ гэрээгээр хэрэглэгчийг Мэдэгдэл хүргэх системд холболт хийх үед үүсэх харилцааг зохицуулна.

1.3.Энэ гэрээнд хэрэглэсэн дараахь нэр томъёог дор дурдсан утгаар ойлгоно:

1.3.1. “Мэдэгдэл хүргэх систем” гэж цахим хэлбэрээр мэдэгдэл хүргэхэд ашиглах системийг;

1.3.2.“Хэрэглэгч” гэж гэрээ байгуулан үндсэн болон дэмжих систем ашиглаж байгаа төрийн байгууллага, хуулийн этгээдийг;

1.3.3. “Төрийн цахим үйлчилгээний зохицуулатын газар” (цаашид “Агентлаг” гэх) нь үндсэн болон дэмжих системээр дамжуулан үйлчилгээ үзүүлэх гэрээг байгуулах үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх, олон нийтэд сурталчлах, сургалт зохион байгуулах, системд холбогдсон байгууллагуудын мэдээллийн системийн бэлэн байдал, гэрээний хэрэгжилтийг хангуулах төрийн захиргааны байгууллагыг;

1.3.4. “Үндэсний дата төв” УТҮГ” (цаашид “Дата төв” гэх) гэж үндсэн системд үйлчилгээний холболтыг хийн, ашиглах нөхцөлийг бүрдүүлж ажиллах байгууллагыг;

1.3.5. “И-Монгол академи” УТҮГ” (цаашид “Академи” гэх) гэж үндсэн системийн хөгжүүлэлтийг хийн, ашиглах нөхцөлийг бүрдүүлж ажиллах байгууллагыг.

1.3.6. “Амжилттай дуудсан сервис” гэж тухайн сервисийг дуудаж байгаа хэрэглэгчид ашиглаж болох хариу буцаасан байхыг.

Хоёр.Талуудын эрх, үүрэг

2.1. Яам нь “Үндсэн системийн үйл ажиллагааг зохицуулах, систем ашиглаж үйлчилгээ үзүүлэх, мэдээлэл солилцох журам”, “Үндсэн болон дэмжих систем ашиглан үйлчилгээ үзүүлэх гэрээний загвар, зардал тооцох аргачлал, гэрээ байгуулах журам”-д зааснаас гадна дараахь эрх, үүрэгтэй:

2.1.1. Гэрээний хэрэгжилтийн дүгнэх, хэрэгжилтийг сайжруулах талаар гэрээний нөгөө тал болон агентлаг, дата төв, академид зөвлөмж, чиглэл хүргүүлэх;

2.1.2. Үндсэн болон дэмжих системээр дамжуулан хүн, хуулийн этгээдэд үйлчилгээ үзүүлэх үйл ажиллагааг нэгдсэн зохион байгуулалтаар хангаж, хяналт тавих;

2.1.3. Үндсэн болон дэмжих системтэй холбоотой гаргасан хүсэлтийг хүлээн авах, бүртгэх, шийдвэрлэх, эрх бүхий байгууллагад шилжүүлж шийдвэрлүүлэх;

2.1.4. Үндсэн болон дэмжих системийн үйлчилгээ үзүүлэх, тайлагнах үйл ажиллагааг нэгдсэн зохион байгуулалтаар хангах;

2.1.5. Үндсэн болон дэмжих системээр үзүүлж буй үйлчилгээтэй холбоотой асуудлаар зөвлөгөө, мэдээлэл өгөх;

2.1.6. Үндсэн болон дэмжих системээр мэдээлэл солилцох холболт, техникийн хэвийн үйл ажиллагааг хангах;

2.1.7. Үндсэн болон дэмжих систем, сүлжээнд техникийн үзлэг, шалгалтын улмаас түр зогсолт хийх, гэмтэл, саатал гарсан тохиолдолд шаардлагатай арга хэмжээг авч хэрэгжүүлэх;

2.1.8. Үндсэн болон дэмжих системийн түүхчилсэн бүртгэлийг хөтлөх, төлбөр тооцохтой холбоотой үйл ажиллагааг хариуцах;

2.1.9. Техникийн нөхцөл, шаардлагын дагуу үндсэн болон дэмжих системийн хөгжүүлэлтийг хийх, үйлчилгээг байршуулах;

2.1.10. Хэрэглэгчид мэдэгдлийг хүргэх нөхцөлийг бүрдүүлж, эрх нээж өгөх, холбогдох ажилтнуудад заавар, зөвлөмж хүргэх;

2.1.11. Гэрээ байгуулсан хуулийн этгээдэд гэрээнд заасан үүргээ биелүүлэх талаар шаардлага тавих, гарсан зөрчлийг арилгуулах;

2.1.12. Хэрэглэгчийн ашиглаж байгаа систем, сүлжээнд техникийн үзлэг, шалгалт хийх, техникийн нөхцөл, шаардлагыг хангаж байгаа эсэхийг дүгнэх, зөвлөмж хүргүүлэх;

2.2. Агентлаг нь гэрээний 2.1.3, 2.1.4, 2.1.5, 2.1.11 -т заасан үүргийг, Дата төв нь 2.1.6, 2.1.7, 2.1.8, 2.1.11, 2.1.12. -т заасан үүргийг, Академи нь энэ гэрээний 2.1.9, 2.1.10, 2.1.12.-т заасан үүргийг тус тус хэрэгжүүлнэ.

2.3. Хэрэглэгч нь “Үндсэн системийн үйл ажиллагааг зохицуулах, систем ашиглаж үйлчилгээ үзүүлэх, мэдээлэл солилцох журам”, Үндсэн болон дэмжих систем ашиглан үйлчилгээ үзүүлэх гэрээний загвар, зардал тооцох аргачлал, гэрээ байгуулах журам”-д зааснаас гадна дараахь эрх, үүрэгтэй:

2.3.1. Хяналтын системд хэрэглэгчийн бүртгэл үүсгүүлэх, хэрэглэгч өөрчлөгдсөн тохиолдолд тухай бүр мэдэгдэж, шинэчлүүлэх;

2.3.2. Өөрийн хариуцан ажиллаж байгаа сервер болон мэдээллийн сангийн тасалдалгүй найдвартай ажиллагааг хангах;

2.3.3. Дэмжих системийн техникийн нөхцөл, шаардлагыг хангах талаар гарсан аливаа доголдлыг шийдвэрлүүлэх;

2.3.4. Мэдэгдэл хүргэх системээр дамжуулан тусгай дугаарт мэдэгдэл хүргэх бол төлбөрийг хариуцах;

2.3.5. Системд холбогдон үйлчилгээ авахад ашиглаж буй токен, нэвтрэх эрхийг бусдад ашиглуулахгүй байх;

2.3.6. Гэрээ цуцлах, гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулах саналыг хүргүүлэх.

Гурав.Гэрээний хугацаа

3.1. Үндсэн систем болон дэмжих системээс үйлчилгээ үзүүлэх гэрээний хугацаа 3 жил байна.

3.2. Хэрэглэгч энэ гэрээний 3.1-д заасан хугацааг сунгах тухай хүсэлт ирүүлээгүй тохиолдолд гэрээг анх байгуулсан хугацаагаар сунгагдсанд тооцно.

3.3. Гэрээ байгуулсанаас хойш үйлчилгээ нэмж авах тохиолдолд нэмэлт гэрээ байгуулна.

Дөрөв.Гэрээний төлбөр

4.1. Академи нь “Үндсэн болон дэмжих систем ашиглан үйлчилгээ үзүүлэх гэрээний загвар, зардал тооцох аргачлал, гэрээ байгуулах журам”-ын 1.2-т заасны дагуу тооцсон гэрээний төлбөрийг сар бүрийн 1-ний өдрөөс тухайн сарын сүүлийн өдрөөр тасалбар болгон дараа сарын 10-ны өдрийн дотор нэхэмжилнэ.

4.2.Хэрэглэгч нь тухайн сарын төлбөрийг дараа сарын 20-ны өдрийн дотор Академийн _____ тоот дансанд шилжүүлнэ.

Тав.Давагдашгүй хүчин зүйлс

5.1.“Давагдашгүй хүчин зүйлс” гэж гэрээний талууд урьдчилан таамаглаагүй, мэдэх боломжгүй буюу түүнийг шийдвэрлэхэд нэн бэрхшээлтэй нөхцөл байдал, гал түймэр, газар хөдлөлт, салхи шуурга, аянга цахилгаан, үер усны зэрэг байгалийн гамшиг, нийтийг хамарсан эмх замбараагүй байдал, үймээн самуун, ажил хаялт, гоц халдварт өвчин, цар тахал дэлгэрэх, улс орныг хамарсан онц бөгөөд дайн бүхий байдал үүсэх, террорист халдлага, төрийн эрх бүхий байгууллагын шийдвэр, хорио цээрийн дэглэм тогтоох, удаан хугацааны эрчим хүчний тасалдал зэрэг талуудын санаа зоригоос гадуур үүсэж болох нөхцөлүүдийг ойлгоно.

5.2.Давагдашгүй хүчин зүйлсийн улмаас талуудын аль нэг тал нь гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэх боломжгүй болсон тохиолдолд гэрээний нөгөө талд ажлын 3 өдрийн дотор мэдэгдэх ба үүрэг хүлээх хугацаа нь тухайн нөхцөл байдал үргэлжлэх хугацаагаар хойшлогдоно.

5.3.Давагдашгүй хүчин зүйл үүссэн тохиолдолд гуравдагч этгээд буюу эрх бүхий байгууллагаас нотолсон баримтыг гаргуулж авна.

5.4.Давагдашгүй хүчин зүйл бий болсон нь хуанлийн нэг сараас дээш хугацаагаар үргэлжилбэл талууд асуудлыг харилцан зөвшилцөх замаар шийдвэрлэнэ.

Зургаа.Талуудын хүлээх хариуцлага

6.1.Талууд гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүйгээс үүссэн аливаа хохирлыг хариуцан, гэрээний нөгөө талд барагдуулна.

6.2.Хэрэглэгч нь гэрээнд заасан төлбөр төлөх хугацааг хэтрүүлсэн тохиолдолд Академи төв нь үйлчилгээний хандах эрхийг түр хугацаагаар хязгаарлана.

Долоо.Гэрээнээс үүдэлтэй маргаан шийдвэрлэх

7.1.Гэрээнээс үүссэн аливаа маргааныг үл маргах буюу харилцан зөвшилцөх замаар шийдвэрлэхийг эрмэлзэнэ.

7.2.Гэрээний талууд харилцан зөвшилцөж чадаагүй тохиолдолд хуульд заасан журмын дагуу шүүхэд хандаж шийдвэрлүүлнэ.

Найм.Бусад зүйлс

8.1.Талууд энэ гэрээний 2.2-т зааснаас бусад үүргээ гуравдагч этгээдэд хэсэгчлэн болон бүрэн хэмжээгээр шилжүүлэхгүй.

8.2. Аль нэг тал нь уг гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулах, гэрээг цуцлах саналыг нөгөө талдаа урьдчилан мэдэгдэж хамтран шийдвэрлэнэ.

8.3.Энэ гэрээг талууд тоон гарын үсгээр баталгаажуулснаар хүчин төгөлдөр болох ба гэрээг 2 хувь үйлдэж, тус бүр нэг хувийг хадгалах бөгөөд хувь тус бүр хууль зүйн хувьд ижил хүчинтэй байна.

Талуудын хаяг:

Хаяг: Чингэлтэй дүүрэг, 1-р хороо,
Энх тайвны өргөн чөлөө,
Сүхбаатарын талбай-1, Төв
шуудан, Цахим хөгжил, харилцаа
холбооны яам.

Утас: +976-11330781

Факс:

Цахим хуудас: www.mddc.gov.mn

Цахим шуудан: info@mddc.gov.mn

Хаяг.....

Утас:

Факс:

Цахим хуудас:

Цахим шуудан:

Гэрээ байгуулсан:

Цахим хөгжил, харилцаа холбооны яамыг
төлөөлж:

..... (албан тушаал)

..... (эцэг/эх/-ийн нэр, нэр)

..... (албан тушаал)

..... (эцэг/эх/-ийн нэр, нэр)

..... (албан тушаал)

.....(эцэг/эх/-ийн нэр, нэр)

(тамга, тэмдэг)

.....: төлөөлж:

.....

.....

(тамга, тэмдэг)

“Үндсэн болон дэмжих систем ашиглан
үйлчилгээ үзүүлэх гэрээний загвар, зардал
тооцох аргачлал, гэрээ байгуулах журам”-ын
5 дугаар хавсралт

БАТЛАВ.

БАТЛАВ.

ТӨРИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ НЭГДСЭН СИСТЕМ АШИГЛАН ҮЙЛЧИЛГЭЭ ҮЗҮҮЛЭХ ГЭРЭЭНИЙ ЗАГВАР

№ ...

2025 оны ... дугаар

Улаанбаатар хот

Энэхүү гэрээг нэг талаас Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яам (цаашид
“яам” гэх), түүнийг төлөөлж _____
(албан тушаал, эцэг/эх/-ийн нэр, нэр),

Нөгөө талаас _____
(цаашид “Хэрэглэгч” гэх), түүнийг төлөөлж _____
(албан тушаал, эцэг/эх/-ийн нэр, нэр)
нар (хамтад нь “Талууд” гэх) дор дурдсан нөхцөлийг харилцан тохиролцож гэрээг
байгуулав.

Нэг.Нийтлэг үндэслэл

1.1. Талууд гэрээгээр хүлээсэн үүргээ хэрэгжүүлэхдээ Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хууль, Цахим гарын үсгийн тухай хууль, Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хууль, “И-Монгол академи” улсын төсөвт үйлдвэрийн газрын дүрэм, “Үндэсний дата төв” улсын төсөвт үйлдвэрийн газрын дүрэм, “Үндсэн системийн үйл ажиллагааг зохицуулах, систем ашиглаж үйлчилгээ үзүүлэх, мэдээлэл солилцох журам”, “Үндсэн болон дэмжих систем ашиглан үйлчилгээ үзүүлэх гэрээний загвар, зардал тооцох аргачлал, гэрээ байгуулах журам”, Үндсэн систем, дэмжих системийн техникийн нөхцөл, шаардлага, заавар, аргачлал болон бусад холбогдох хууль тогтоомж, эрх зүйн актыг дагаж мөрдөнө.

1.2.Энэхүү гэрээгээр хэрэглэгчийг Төрийн үйлчилгээний нэгдсэн системд холбох үед үүсэх харилцааг зохицуулна.

1.3.Энэ гэрээнд хэрэглэсэн дараахь нэр томъёог дор дурдсан утгаар ойлгоно:

1.3.1.“Төрийн үйлчилгээний нэгдсэн систем” гэж нийтийн мэдээлэл, төрийн болон бусад үйлчилгээг цахим хэлбэрээр хүргэх системийг;

1.3.2.“Хэрэглэгч” гэж гэрээ байгуулан үндсэн болон дэмжих систем ашиглаж байгаа төрийн байгууллага, хуулийн этгээдийг;

1.3.3. “Төрийн цахим үйлчилгээний зохицуулатын газар” (цаашид “Агентлаг” гэх) нь үндсэн болон дэмжих системээр дамжуулан үйлчилгээ үзүүлэх гэрээг байгуулах үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх, олон нийтэд сурталчлах, сургалт зохион байгуулах, системд холбогдсон байгууллагуудын мэдээллийн системийн бэлэн байдал, гэрээний хэрэгжилтийг хангуулах төрийн захиргааны байгууллагыг;

1.3.4. “Үндэсний дата төв” УТҮГ” (цаашид “Дата төв” гэх) гэж үндсэн системд үйлчилгээний холболтыг хийн, ашиглах нөхцөлийг бүрдүүлж ажиллах байгууллагыг;

1.3.5. “И-Монгол академи” УТҮГ” (цаашид “Академи” гэх) гэж үндсэн системийн хөгжүүлэлтийг хийн, ашиглах нөхцөлийг бүрдүүлж ажиллах байгууллагыг.

Хоёр.Талуудын эрх, үүрэг

2.1. Яам нь “Үндсэн системийн үйл ажиллагааг зохицуулах, систем ашиглаж үйлчилгээ үзүүлэх, мэдээлэл солилцох журам”, “Үндсэн болон дэмжих систем ашиглан үйлчилгээ үзүүлэх гэрээний загвар, зардал тооцох аргачлал, гэрээ байгуулах журам”-д зааснаас гадна дараахь эрх, үүрэгтэй:

2.1.1. Гэрээний хэрэгжилтийн дүгнэх, хэрэгжилтийг сайжруулах талаар гэрээний нөгөө тал болон агентлаг, дата төв, академид зөвлөмж, чиглэл хүргүүлэх;

2.1.2. Үндсэн болон дэмжих системээр дамжуулан хүн, хуулийн этгээдэд үйлчилгээ үзүүлэх үйл ажиллагааг нэгдсэн зохион байгуулалтаар хангаж, хяналт тавих;

2.1.3. Үндсэн болон дэмжих системтэй холбоотой гаргасан хүсэлтийг хүлээн авах, бүртгэх, шийдвэрлэх, эрх бүхий байгууллагад шилжүүлж шийдвэрлүүлэх;

2.1.4. Үндсэн болон дэмжих системийн үйлчилгээ үзүүлэх, тайлагнах үйл ажиллагааг нэгдсэн зохион байгуулалтаар хангах;

2.1.5. Үндсэн болон дэмжих системээр үзүүлж буй үйлчилгээтэй холбоотой асуудлаар зөвлөгөө, мэдээлэл өгөх;

2.1.6. Үндсэн болон дэмжих системээр мэдээлэл солилцох холболт, техникийн хэвийн үйл ажиллагааг хангах;

2.1.7. Үндсэн болон дэмжих систем, сүлжээнд техникийн үзлэг, шалгалтын улмаас түр зогсолт хийх, гэмтэл, саатал гарсан тохиолдолд шаардлагатай арга хэмжээг авч хэрэгжүүлэх;

2.1.8. Үндсэн болон дэмжих системийн түүхчилсэн бүртгэлийг хөтлөх, төлбөр тооцохтой холбоотой үйл ажиллагааг хариуцах;

2.1.9. Техникийн нөхцөл, шаардлагын дагуу үндсэн болон дэмжих системийн хөгжүүлэлтийг хийх, үйлчилгээг байршуулах;

2.1.10. Төрийн үйлчилгээний нэгдсэн системийг ашиглах, системд холбогдох зааварчилгаа, мэдээллийг өгөх;;

2.1.11. Гэрээ байгуулсан хуулийн этгээдэд гэрээнд заасан үүргээ биелүүлэх талаар шаардлага тавих, гарсан зөрчлийг арилгуулах;

2.1.12. Хэрэглэгчийн ашиглаж байгаа систем, сүлжээнд техникийн үзлэг, шалгалт хийх, техникийн нөхцөл, шаардлагыг хангаж байгаа эсэхийг дүгнэх, зөвлөмж хүргүүлэх;

2.2. Агентлаг нь гэрээний 2.1.3, 2.1.4, 2.1.5, 2.1.11 -т заасан үүргийг, Дата төв нь 2.1.6, 2.1.7, 2.1.8, 2.1.11, 2.1.12. -т заасан үүргийг, Академи нь энэ гэрээний 2.1.9, 2.1.10, 2.1.12.-т заасан үүргийг тус тус хэрэгжүүлнэ.

2.3. Хэрэглэгч нь “Үндсэн системийн үйл ажиллагааг зохицуулах, систем ашиглаж үйлчилгээ үзүүлэх, мэдээлэл солилцох журам”, Үндсэн болон дэмжих систем ашиглан үйлчилгээ үзүүлэх гэрээний загвар, зардал тооцох аргачлал, гэрээ байгуулах журам”-д зааснаас гадна дараахь эрх, үүрэгтэй:

2.3.1. Хяналтын системд хэрэглэгчийн бүртгэл үүсгүүлэх, хэрэглэгч өөрчлөгдсөн тохиолдолд тухай бүр мэдэгдэж, шинэчлүүлэх;

2.3.2. Өөрийн хариуцан ажиллаж байгаа сервер болон мэдээллийн сангийн тасалдалгүй найдвартай ажиллагааг хангах;

2.3.3. Үндсэн болон дэмжих системийн техникийн нөхцөл, шаардлагыг хангах талаар гарсан аливаа доголдлыг шийдвэрлүүлэх;

2.3.4. Тасалдал, саатлыг бүртгэгдсэнээс хойш нэн даруй арга хэмжээ авах;

2.3.5. Төрийн үйлчилгээний нэгдсэн системд холбогдсон системийг шинэчлэх, холбогдох туршилт хийх тухай бүр үйлчилгээ үзүүлэгч байгуулагад урьдчилан мэдэгдэх;

2.3.6. Танилт, нэвтрэлтийн системд холбогдон үйлчилгээ авахад ашиглаж буй токен, нэвтрэх эрхийг бусдад ашиглуулахгүй байх;

2.3.7. Гэрээ цуцлах, гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулах саналыг хүргүүлэх.

Гурав.Гэрээний хугацаа

3.1. Үндсэн систем болон дэмжих системээс үйлчилгээ үзүүлэх гэрээний хугацаа 3 жил байна.

3.2. Хэрэглэгч энэ гэрээний 3.1-д заасан хугацааг сунгах тухай хүсэлт ирүүлээгүй тохиолдолд гэрээг анх байгуулсан хугацаагаар сунгагдсанд тооцно.

3.3. Гэрээ байгуулсанаас хойш үйлчилгээ нэмж авах тохиолдолд нэмэлт гэрээ байгуулна.

Дөрөв.Гэрээний төлбөр

4.1.Академи нь “Үндсэн болон дэмжих систем ашиглан үйлчилгээ үзүүлэх гэрээний загвар, зардал тооцох аргачлал, гэрээ байгуулах журам”-ын 1.2-т заасны дагуу тооцсон гэрээний төлбөрийг сар бүрийн 1-ний өдрөөс тухайн сарын сүүлийн өдрөөр тасалбар болгон дараа сарын 10-ны өдрийн дотор нэхэмжилнэ.

4.2.Хэрэглэгч нь тухайн сарын төлбөрийг дараа сарын 20-ны өдрийн дотор Академийн_____ тоот дансанд шилжүүлнэ.

Тав.Давагдашгүй хүчин зүйлс

5.1.“Давагдашгүй хүчин зүйлс” гэж гэрээний талууд урьдчилан таамаглаагүй, мэдэх боломжгүй буюу түүнийг шийдвэрлэхэд нэн бэрхшээлтэй нөхцөл байдал, гал

түймэр, газар хөдлөлт, салхи шуурга, аянга цахилгаан, үер усны зэрэг байгалийн гамшиг, нийтийг хамарсан эмх замбараагүй байдал, үймээн самуун, ажил хаялт, гоц халдварт өвчин, цар тахал дэлгэрэх, улс орныг хамарсан онц бөгөөд дайн бүхий байдал үүсэх, террорист халдлага, төрийн эрх бүхий байгууллагын шийдвэр, хорио цээрийн дэглэм тогтоох, удаан хугацааны эрчим хүчний тасалдал зэрэг талуудын санаа зоригоос гадуур үүсэж болох нөхцөлүүдийг ойлгоно.

5.2.Давагдашгүй хүчин зүйлсийн улмаас талуудын аль нэг тал нь гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэх боломжгүй болсон тохиолдолд гэрээний нөгөө талд ажлын 3 өдрийн дотор мэдэгдэх ба үүрэг хүлээх хугацаа нь тухайн нөхцөл байдал үргэлжлэх хугацаагаар хойшлогдоно.

5.3.Давагдашгүй хүчин зүйл үүссэн тохиолдолд гуравдагч этгээд буюу эрх бүхий байгууллагаас нотолсон баримтыг гаргуулж авна.

5.4.Давагдашгүй хүчин зүйл бий болсон нь хуанлийн нэг сараас дээш хугацаагаар үргэлжилбэл талууд асуудлыг харилцан зөвшилцөх замаар шийдвэрлэнэ.

Зургаа.Талуудын хүлээх хариуцлага

6.1.Талууд гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүйгээс үүссэн аливаа хохирлыг хариуцан, гэрээний нөгөө талд барагдуулна.

6.2.Хэрэглэгч нь гэрээнд заасан төлбөр төлөх хугацааг хэтрүүлсэн тохиолдолд Академи нь үйлчилгээний хандах эрхийг түр хугацаагаар хязгаарлана.

Долоо.Гэрээнээс үүдэлтэй маргаан шийдвэрлэх

7.1.Гэрээнээс үүссэн аливаа маргааныг үл маргах буюу харилцан зөвшилцөх замаар шийдвэрлэхийг эрмэлзэнэ.

7.2.Гэрээний талууд харилцан зөвшилцөж чадаагүй тохиолдолд хуульд заасан журмын дагуу шүүхэд хандаж шийдвэрлүүлнэ.

Найм.Бусад зүйлс

8.1.Талууд нь энэ гэрээний 2.2-т зааснаас бусад үүргээ гуравдагч этгээдэд хэсэгчлэн болон бүрэн хэмжээгээр шилжүүлэхгүй.

8.2. Аль нэг тал нь уг гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулах, гэрээг цуцлах саналыг нөгөө талдаа урьдчилан мэдэгдэж хамтран шийдвэрлэнэ.

8.3.Энэ гэрээг талууд тоон гарын үсгээр баталгаажуулснаар хүчин төгөлдөр болох ба гэрээг 2 хувь үйлдэж, тус бүр нэг хувийг хадгалах бөгөөд хувь тус бүр хууль зүйн хувьд ижил хүчинтэй байна.

Ес.Гэрээний хавсралт

9.1.Доорх хавсралт нь гэрээний салшгүй хэсэг байна.

9.1.1.хавсралт: Төрийн үйлчилгээний нэгдсэн системээр үзүүлэх _____
үйлчилгээний мэдээлэл _____ хуудас.

Талуудын хаяг:

Хаяг: Чингэлтэй дүүрэг, 1-р хороо,
Энхтайвны өргөн чөлөө,
Сүхбаатарын талбай-1, Төв
шуудан, Цахим хөгжил, инновац,
харилцаа холбооны яам.

Утас: +976-11330781

Факс:

Цахим хуудас: www.mddic.gov.mn

Цахим шуудан: info@mddic.gov.mn

Хаяг:

Утас:

Факс:

Цахим хуудас:

Цахим шуудан:

Гэрээ байгуулсан:

Цахим хөгжил, инновац, харилцаа
холбооны яамыг төлөөлж:

..... (албан тушаал)

..... (эцэг/эх/-ийн нэр, нэр)

..... (албан тушаал)

.....(эцэг/эх/-ийн нэр, нэр)

..... (албан тушаал)

.....(эцэг/эх/-ийн нэр, нэр)

(тамга, тэмдэг)

.....: төлөөлж:

.....

.....

(тамга, тэмдэг)

Журмын 5 дугаар хавсралтаар баталсан
гэрээний загварын хавсралт

ТӨРИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ НЭГДСЭН СИСТЕМЭЭР
ҮЗҮҮЛЭХ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ МЭДЭЭЛЭЛ

№	Үйлчилгээний нэр	Ангилал	Үйлчилгээний хураамж	Үзүүлэх горим			Шийдвэрлэх хугацаа
				Вэб портал	Гар утасны аппликэйшн	Оператор	
1							
2							
3							

“Үндсэн болон дэмжих систем ашиглан үйлчилгээ үзүүлэх гэрээний загвар, зардал тооцох аргачлал, гэрээ байгуулах журам”-ын 6 дугаар хавсралт

ҮНДСЭН БОЛОН ДЭМЖИХ СИСТЕМ АШИГЛАН ҮЙЛЧИЛГЭЭ ҮЗҮҮЛЭХЭД ЗАРДАЛ ТООЦОХ АРГАЧЛАЛ

Нэг.Нийтлэг үндэслэл

1.1.Энэ аргачлалыг “Үндэсний дата төв” УТҮГ болон “И-Монгол академи” УТҮГ нь үндсэн болон дэмжих системээр дамжуулан хуулийн этгээдэд үзүүлж байгаа үйлчилгээний зардлыг тооцоход баримтална.

Хоёр.Үндсэн болон дэмжих систем ашиглан үзүүлэх үйлчилгээний зардал тооцох

2.1.Үндсэн болон дэмжих систем ашиглан үзүүлэх үйлчилгээний зардлыг “Үндсэн системийн үйл ажиллагааг зохицуулах, систем ашиглаж үйлчилгээ үзүүлэх, мэдээлэл солилцох журам”-ын 3.2-т заасны дагуу “Үндэсний дата төв” УТҮГ болон “И-Монгол академи” УТҮГ тооцох бөгөөд цахим хөгжил, харилцаа холбооны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага хяналт тавина.

Гурав.Зардал тооцох аргачлал

3.1.Зардлыг тооцохдоо “Өртөгт суурилсан арга”-ын “Дээрээс доош” аргачлалыг баримталж, зардлыг өртөгт суурилан бүрэн хуваарилах зарчимд үндэслэнэ.

3.2.“Дээрээс доош” аргачлал нь дараахь 5 үе шатаас бүрдэнэ:

3.2.1.байгууллагын үйлчилгээний төрлүүдийг тодорхойлох;

3.2.2.бүх зардал ба хөрөнгийг тодорхойлох бөгөөд салгах;

3.2.3.шууд хамаарах бүх зардлыг хуваарилах;

3.2.4.нийтлэг болон хуваагдах боломжтой зардлуудыг дахин хуваарилах;

3.2.5.нэгжийн өртөг тооцоолох.

3.3.Энэ журмын 3.2-т заасан аргачлал нь байгууллагын одоогийн үйл ажиллагааны зардалд тулгуурлана.

Дөрөв.Байгууллагын үйлчилгээний төрлүүдийг тодорхойлох

4.1.Байгууллагын үйлчилгээний төрлийг төлбөртэй болон төлбөргүй байдлаар тодорхойлох бөгөөд үйлчилгээний төрлийг жишээ байдлаар Хүснэгт 1-д үзүүлэв.

Хүснэгт 1

Байгууллагын үзүүлж байгаа үйлчилгээний төрөл

№	Үйлчилгээний нэр, төрөл	Төлбөртэй	Төлбөргүй
1	Үйлчилгээ 1		*
2	Үйлчилгээ 2		*
3	Үйлчилгээ 3		*
4	Үйлчилгээ 4	*	*

Тайлбар: Дээрх үйлчилгээг “Үндсэн системийн үйл ажиллагааг зохицуулах, систем ашиглаж үйлчилгээ үзүүлэх, мэдээлэл солилцох журам”-ын дагуу төрийн байгууллагад үнэ төлбөргүй үзүүлэх бөгөөд хуулийн этгээдэд тодорхой төлбөртэйгээр үзүүлнэ.

Тав.Бүх зардал ба хөрөнгийг
тодорхойлох бөгөөд салгах

5.1.Нийт зардал болон бүртгэлд байгаа хөрөнгийг тодорхойлж ялган, нэгж өртөг тооцох үйлчилгээнд хамаарах шууд болон шууд бус зардлыг бусад зардал, хөрөнгөөс салган дараахь байдлаар тооцно:

5.1.1.үнэ тогтоох шаардлага бүхий үйлчилгээнд хамаарах хөрөнгө болон шууд зардлыг бусад зардал, хөрөнгөөс салгах;

5.1.2.бусад хөрөнгийн элэгдлийн зардлыг шууд бус зардал гэж үзэн бүх үйлчилгээнд хуваарилах.

Зургаа.Шууд хамаарах бүх зардлыг хуваарилах

6.1.Байгууллагын хэмжээнд гарч байгаа нийт зардлаас шууд болон шууд бус зардалд хуваарилагдах зардлын төрлийг сонгож, бодит гүйцэтгэлд суурилан хуваарилах бөгөөд жишээг Хүснэгт 2-т, шууд зардлыг үйлчилгээнд хуваарилсан жишээг Хүснэгт 3-т үзүүлэв.

Хүснэгт 2

Зардлын ангилал, шууд хамаарагдах зардлыг
холбогдох үйлчилгээнд хуваарилах

№	Зардлын төрөл	Тоо хэмжээ	Зардлын дүн	Шууд зардал	Шууд бус зардал
---	---------------	------------	-------------	-------------	-----------------

	Зардлын төрөл 1				
1	Зардал 1	*	*	*	*
2	Зардал 2	*	*	*	*
3	Зардал 3	*	*	*	*
	Нийт	*	*	*	*
	Зардлын төрөл 2				
1	Зардал 1	*	*	*	*
2	Зардал 2	*	*	*	*
3	Зардал 3	*	*	*	*
	Нийт	*	*	*	*
	Нийт дүн	*	*	*	*

Хүснэгт 3

Шууд зардлыг үйлчилгээнд хуваарилсан байдал

№	Зардлын төрөл	Шууд зардал	Үйлчилгээ 1	Үйлчилгээ 2
	Зардлын төрөл 1			
1	Зардал 1	*	*	*
2	Зардал 2	*	*	*
3	Нийт	*	*	*
	Зардлын төрөл 2			
1	Зардал 1	*	*	*
2	Зардал 2	*	*	*
3	Нийт	*	*	*
	Нийт дүн	*	*	*

Долоо.Нийтлэг болон хуваагдах боломжтой зардлуудыг дахин хуваарилах

7.1.Байгууллагын нийт зардлаас тухайн үйлчилгээнд хамаарах зардлыг тооцоолон ялгаж, үлдэх зардлыг шууд бус зардалд хуваарилна. Шууд бус зардлууд нь тухайн үйлчилгээ болон бусад үйлчилгээнд хуваарилагдах замаар зардлын чиглүүлэгчийг тодорхойлох бөгөөд жишээг Хүснэгт 4-т үзүүлэв.

7.2.Шууд бус зардлыг Зардлын чиглүүлэгчийг ашиглан үйлчилгээ тус бүрээр тооцох бөгөөд жишээг Хүснэгт 5-д үзүүлэв.

7.3.Зардлын чиглүүлэгчид үндэслэн шууд бус зардлыг үйлчилгээ тус бүрд хуваарилах бөгөөд жишээг Хүснэгт 6-д үзүүлэв.

7.4.Тухайн үйлчилгээнд хамаарах шууд болон шууд бус зардал, хөрөнгө оруулалтын зардлыг нэгтгэж тооцох бөгөөд жишээг Хүснэгт 7-д үзүүлэв.

Хүснэгт 4

Шууд бус зардлуудыг хуваарилах үйлчилгээний төрөл

№	Үзүүлэлт	Үйлчилгээ1	Үйлчилгээ 2	Бусад
1	Шууд бус зардал 1	*	*	*
2	Шууд бус зардал 2	*	*	*
3	Шууд бус зардал 3	*	*	*
	Нийт зардлын дүн	*	*	*

Хүснэгт 5

Зардлын чиглүүлэгч

Үйл ажиллагааны зардлын төрөл	Зардлын чиглүүлэгч
Зардлын төрөл 1	Чиглүүлэгч 1
Зардлын төрөл 2	Чиглүүлэгч 2
Зардлын төрөл 3	Чиглүүлэгч 3

Тайлбар: Зардлын чиглүүлэгчийг ажилчдын тоонд үндэслэн хуваарилах нь илүү оновчтой. Учир нь тухайн байгууллагад ажиллаж байгаа ажилтан, албан хаагчид тухайн байгууллагын нийт үйл ажиллагаанд бүгд хамааралтай бөгөөд үүнтэй холбоотойгоор зардлын хуваарилагч байх бүрэн боломжтой. Харин эд хогшил, урсгал засварын зардал болон элэгдлийн зардлын чиглүүлэгч нь тухайн хөрөнгөд эзлэх хувийн жингээр тодорхойлогдох нь илүү оновчтой.

Хүснэгт 6

Шууд бус зардлыг хуваарилах

Үйл ажиллагааны зардлын төрөл	Зардлын чиглүүлэгч	Үйлчилгээ 1	Үйлчилгээ 2	Бусад үйлчилгээ
Зардлын төрөл 1	Чиглүүлэгч 1	*	*	*
Зардлын төрөл 2	Чиглүүлэгч 2	*	*	*
Нийт дүн		*	*	*

Хүснэгт 7

Хөрөнгө оруулалт болон зардлын нэгтгэл

№	Зардлын төрөл	Үйлчилгээ 1	Үйлчилгээ 2	Нийт дүн
1	Үндсэн хөрөнгөд хийсэн санхүүжилт	*	*	*
2	Шууд зардал	*	*	*
3	Шууд бус зардал	*		*
	Нийт дүн			*

Найм.Нэгжийн өртөг тооцоолох

8.1.Нэгжийн өртгийг тооцоолохдоо тухайн үйлчилгээнд хуваарилагдсан бүх зардлыг нэгжийн суурь үзүүлэлтэд харьцуулна:

8.1.1.Нэгжийн өртөг = Нэгж үйлчилгээний зардлын нийт дүн/Нэгжийн суурь үзүүлэлт.

8.2.Нэгжийн суурь үзүүлэлтийг тооцоолохдоо:

8.2.1.Үндсэн системийн хувьд “ХУР”-д холбогдож амжилттай дуудсан хандалтаас хамаарна;

8.2.2.Дэмжих системийн хувьд систем тус бүрийн онцлогоос шалтгаалж үйлчилгээ авч байгаа хүн, хуулийн этгээдийн тоо, ашиглагдаж байгаа системийн тоо, илгээгдсэн мэдэгдлийн тоо, амжилттай үйлчилгээ авсан нийт тооноос хамаарна.

---o0o---